



СОЁМБО




БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2021.02.04 №05 (10734)

Үнэ 500 төгрөг

— Дугаар эрхэлсэн дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯРТ ТӨРИЙН ТАМГЫГ ГАРДУУЛЛАА



Монгол Улсын 32 дахь Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн тэргүүлэх Засгийн газарт Батлан хамгаалахын сайдаар Гүрсэдийн Сайханбаяр улиран ажиллахаар болж, Засгийн газрын гишүүний тангаргаа өргөж, захирамжаа гардан авлаа. Монгол Улсын сайд, ЗГХЭГ-ын дарга Ц.Нямдорж БХЯ-нд хүрэлцэн ирж Батлан хамгаалахын сайдад төрийн тамгыг гардуулсан юм. Тэрээр

“Батлан хамгаалахын сайдаар хоёр дахь удаагаа томилогдож байгаад баяр хүргэе. Миний бие 31 жилийн дараа БХЯ-нд ирлээ, сэтгэл маш өндөр байна. БХЯ, ЗХЖШ-ын удирдлагууд Та бүхэн монгол цэргийн түүхэн уламжлалыг хадгалж басхүү өнөө цагт өртөөлөн түүчээлж, цэргийн бодлогыг хэрэгжүүлэх өндөр хариуцлагыг хүлээсэн хүмүүс” гэж онцлоод ажлын өндөр амжилт хүслээ.

БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ МЭДЛЭГ, ДАДЛАГА, ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛЫГ ГОЛ ЗОРИЛТОО БОЛГОН ХЭРЭГЖҮҮЛЭЭРЭЙ

Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалтын төгсгөлд Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаярын өгсөн үүрэг чиглэлийг бүрэн эхээр нь хүргэж байна

Зэвсэгт хүчний 2020 оны удирдах бүрэлдэхүүний стратегийн цугларалтыг “Стратегийн төлөвлөлт” сэдвийн хүрээнд явуулж байсан бол энэ удаагийн цугларалтаар өмнөх сэдэвтэй нэн хамаарал бүхий “Операцийн төлөвлөлт” гэсэн сэдвийг сонгон авсан нь оновчтой болжээ гэж үзэж байна.

Монгол Улсын төрөөс “Мэргэжлийн цэрэгт суурилсан

стратеги-2030” баримт бичигт “Цэргийн мэргэжлийн өндөр түвшинд бэлтгэгдсэн бие бүрэлдэхүүн, шинжлэх ухаан, технологийн дэвшилд суурилсан орчин үеийн зэвсэглэл, цэргийн техник бүхий чадварлаг Зэвсэгт хүчнийг байгуулах” гэсэн томоохон зорилгыг дэвшүүлсэн явдал нь бидний алсын хараа, зорилго, зорилт, хүрэх түвшин тодорхой байна гэсэн үг.

Сайдын ажлыг хүлээн аваад энэхүү зорилтыг хангахын тулд дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүд болох “Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”, “Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-т батлан хамгаалах салбарынхаа

цэргийн шинжлэх ухаан, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлж, цэргийн зориулалттай зарим төрлийн бүтээгдэхүүнийг дотооддоо үйлдвэрлэх, алба хаагчдынхаа алба хаах хугацаанд амьдрах, ажиллах нөхцөлийг сайжруулах гээд олон арга хэмжээг хэрэгжүүлэх юм.

2020 оны 12 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар 2020-2024 онд батлан хамгаалах чиглэлээр хэрэгжүүлэх томоохон бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнүүдэд танилцуулсан.

Үүнд улсын агаарын хилийн хяналтын системийн чадавхыг нэмэгдүүлэх, Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын Дата төвийг байгуулах, ЗХЖШ-ын барилгыг



чадварлаг Зэвсэгт хүчнийг бүрдүүлж бэхжүүлэх” гэсэн эрхэм зорилтыг Та бидний өмнө дэвшүүлээд байгаа. Энэ зорилтыг хэрэгжүүлэх нэгэн чухал хүчин зүйл бол Зэвсэгт хүчний операцийн төлөвлөлтийг шинэчлэх, боловсронгуй болгох явдал мөн.

Эргэн сануулахад, “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогод Батлан хамгаалах, Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх чиглэлээр дэвшүүлсэн “Улс орны батлан хамгаалах тогтолцоог боловсронгуй болгож, чадавхыг бэхжүүлэх” бодлогын зорилтыг бүрэн хэрэгжүүлснээр 2050 онд Монгол Улсын батлан хамгаалах тогтолцоо бүрэн төлөвшсөн, батлан хамгаалах аж үйлдвэрлэл хөгжсөн, нэгдмэл тогтолцоотой, технологичсон, өндөр чадамжтай Зэвсэгт хүчинтэй болсон байна” гэж үзэж байгаа.

Мөн “Төрийн цэргийн байгууллагын хөгжлийн

үйл ажиллагааны тэргүүлэх зорилт, дэд зорилтуудыг тусган баталгаажуулах ажилд анхаарал хандуулан ажиллалаа.

Үүний үр дүнд Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт Батлан хамгаалах, Зэвсэгт хүчин 9 дэд зорилт, 48 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахаар тодорхойлоод байна.

Тухайлбал, хугацаат цэргийн алба хаасан иргэдэд төрийн албанд орох, шатлан дэвших, сурч боловсрох, хөдөлмөр эрхлэх, нийгмийн халамж хүртэх давуу эрх олгох хууль, эрх зүйн зохицуулалтыг бий болгох, Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж хэрэгжүүлэх, орон нутгийн хамгаалалтын тогтолцоог бүрдүүлж, дайчилгааны төлөвлөлтийг шинэчлэх, Зэвсэгт хүчнийг орчин үеийн зэвсэглэл, цэргийн техникээр хангах бодлогыг дэс дараатайгаар хэрэгжүүлэх,

шинээр барих, бага бууны сумны үйлдвэр байгуулах, Налайхын аэродромын үндсэн зурвасыг сэргээн засварлах, Зэвсэгт хүчний анги, байгууллагын мэдлийн тусгай хэрэгцээний газарт албан тушаалын орон сууц барих, “Цэргийн жишиг хотхон” төслийг хэрэгжүүлэх, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарыг туулах чадвар сайтай тусгай зориулалтын болон цэргийн тээврийн хэрэгслээр хангах зэрэг ихээхэн хөрөнгө, хүч шаардсан төсөл, арга хэмжээ багтаж байгаа юм.

Эндээс дүгнэхэд бидний өмнө тавигдсан зорилт, хийж хэрэгжүүлэх ажил тодорхой байна. Гагцхүү та бидний хамтын ажиллагаа, оновчтой зөв зохион байгуулалт, сэтгэл, зүтгэл гаргаж ажиллах зориг ухаан, мэдлэг, ур чадвараас ихээхэн шалтгаан гэдгийг шат шатандаа анхаарах хэрэгтэй.

(Үргэлжлэл нь II нүүрт)

ЦАХИМ ДИПЛОМАТ АЖИЛЛАГААНД УЛС ОРНУУДЫН ЗЭВСЭГТ ХҮЧИН НЭГДЭЖ ЭХЭЛЛЭЭ

Дэлхий нийт “Covid-19” хэмээх цар тахалтай нүүр тулаад жил болж байна. Энэ хугацаанд 100 саяас дээш тооны хүн халдвар авч, 2.1 сая нь нас барж, 72 сая хүн эдгэрчээ. Бүтэн жил өнгөрөхөд халдварын тохиолдлын тоо хасагдах бус өдрөөс өдөрт нэмэгдэн, хүрээгээ тэлсээр байна.

Одоогийн байдлаар дэлхийн нэг сая хүн тутмын 12 мянга нь “COVID-19”-ийн халдвар авч, нэг сая хүн тутамд 275 хүн нас барж байна. Тэр дундаа хорвоог орхиж байгаа таван хүн тутмын нэг нь АНУ-ын иргэд байгаа юм. Дараа нь Энэтхэг Улс орж байгаа бөгөөд нийт 10.6 сая хүн өвчилж, 153 мянган хүн нас баржээ. Гуравдугаарт, Бразил Улс, нийт 8.8 сая хүн халдвар авч, 217 мянган хүн нас бараад байна. Түүнчлэн ОХУ, Их Британи, Франц, Испани, Итали, Турк, Герман Улс халдварын тохиолдлын тоогоор дэлхийд тэргүүлж байна.



Нөгөөтэйгүүр цар тахлын нөлөөгөөр дэлхийн эдийн засаг зогсонги байдалд орж, улс орнууд хөл хорионы дэглэмээ сулруулж, мөн чангалсаар өдийг хүрлээ. 2020 оны сүүлчээс эхлэн “Covid-19”-ийн эсрэг хэд хэдэн вакцин бэлэн болж, дэлхийн улс орнууд хүн амаа вакцинжуулах ажлыг өрнүүлж байна. Богино хугацаанд бүтээсэн вакциннуудын эцсийн үр дүн тодорхойгүй байгааг сацуу вирус ч хувьсан өөрчлөгдөж, хүн төрөлхтнийг төөрөгдүүлсээр байгаа юм.

(Үргэлжлэл нь VII нүүрт)

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГТ ХҮНСНИЙ ТУСЛАМЖ ҮЗҮҮЛЭВ

“Ковид 19” цар тахлын халдвартай тэмцэж буй Цэргийн төв эмнэлгийн бүрэлдэхүүнд хүнсний тусламжтай бараа гардууллаа.

Цуглааныг нээж “Монгол хурандаа” нийгэмлэгийн тэргүүн, бэлтгэл хурандаа Ч.Баатар хэлсэн үгэндээ “Монгол Улс дэлхий нийтийг хамарсан цар тахлын аюултай жил тойрон тэмцэж байна. Өнөөдөр тэмцлийн тэргүүн эгнээнд ажиллаж буй цэргийн эмч, ажилтнуудад “Nabeva Mongol” компаниас нийгмийн хариуцлагынхаа хүрээнд сэтгэлийн дэм үзүүлж байгаад мөрдэс нэгт нөхдийнхөө өмнөөс талархал илэрхийлье” гэв. Тус компанийн Ерөнхий менежер Б.Насанжаргал 5.2 сая төгрөгийн үнэ бүхий хүнсний Цэргийн төв эмнэлгийн ажилтнуудад гардуулж буйдаа баяртай байгаагаа илэрхийлээд, хүн ардынхаа эрүүл энхийн төлөөх үйлсэд их амжилт



гаргахыг хүслээ. Цэргийн төв эмнэлгийн Ерөнхий эмчийн орлогч, штабын дарга, хурандаа Д.Ганболд “Өнгөрсөн хугацаанд бид нийт 617 хүнийг хүлээн авч, 500 орчим хүнийг эмчилж

эдгэрүүлсэн. Манай бүрэлдэхүүн 3 ээлжээр 1052 удаа цар тахлын голомтод үүрэг гүйцэтгэж байна” хэмээн мэдээлсэний зэрэгцээ тус хамт олонд эмч, ажилтнуудынхаа талархлыг уламжиллаа.

БИЕ БҮРЭЛДЭХҮҮНИЙ МЭДЛЭГ, ДАДЛАГА, ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХ АЖЛЫГ ГОЛ ЗОРИЛТОО БОЛГОН ХЭРЭГЖҮҮЛЭЭРЭЙ

(Түрүүч нь I нүүрт)

Энэ талаар ЗХЖШ-ын удирдлага, Зэвсэгт хүчний заах арга зүйн цугларалт, ЗХЖШ-ын 2020 оны үйл ажиллагааны тайлангийн хуралд оролцоходоо хэлж байсны зэрэгцээ хэвлэл, мэдээллийн хэрэгслээр чамгүй мэдээлэл өгсөн. Ер нь улс орныг батлан хамгаалах бодлого, зорилт, Зэвсэгт хүчний үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд өргөнөөр хүргэхийг зорьж байгаа. Энэ ч үүднээс БХЯ, ЗХЖШ-ыг хэвлэл, мэдээллийн ажилтнуудтай болгож, "Соёмбо" сонин, "Дуулга" студийг нэгтгэн "Соёмбо" редакцыг байгуулсан.

Өнгөрсөн жилүүдэд салбарын хэмжээнд эрх зүйн шинэчлэл хурдацтай хийгдэж Зэвсэгт хүчний хэтийн болон дунд хугацааны хөгжлийн бодлого, зорилт тодорхойлогдож, улс оронд үүссэн "Ковид" цар тахлын нөхцөл байдлын улмаас 2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим арга хэмжээ тасалдсан хэдий ч мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлж, бэхжүүлэхэд ахиц гаргасан, Зэвсэгт хүчний удирдлагын байгууллагын тогтолцооны шинэчлэлийн эхлэлийг тавьсан, төрлийн цэргийг шинээр байгуулсан, стратегийн дэлгэн байгуулалт, дайчилгаатай холбоотой стратегийн төлөвлөлтийн томоохон баримт бичгүүдээ батлуулсан, зэвсэг, техник нэгдсэн үйлчилгээ, сэргээн сайжруулалт хийгдэж эхэлсэн, улс орны томоохон бүтээн байгуулалтад Зэвсэгт хүчний олон анги алба хаагчдаа оролцуулсан зэрэг дэвшлүүд гарлаа.

Мөн УИХ-ын 2020 оны ээлжит хаврын чуулганаар Зэвсэгт хүчний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль батлагдаж, шинээр 3 төрлийн цэрэг байгуулагдсан. Үүнийг ч ажил хэрэг болгон Зэвсэгт хүчинд "Тусгай хүчний цэргийн командлал", "Кибер аюулгүй байдлын цэргийн командлал", "Барилга-инженерийн цэргийн удирдах газар" байгуулснаар стратегийн цугларалтад шинэ төрлийн цэргийн командлагч, дарга нар анх удаа оролцож байна.

Та бүгдийг шинэ төрлийн цэргийг эхнээс нь эмхлэн зохион байгуулах, бүрдүүлж бэхжүүлэх үйлсэд тань амжилт хүсье. Аливаа зүйлийг эхлүүлэх төвөгтэй, бас ээдрээтэй. Гэвч үүнийг манай Зэвсэгт хүчний Төрлийн цэргийн шинэ дарга нар хийж чадна гэдэгт итгэлтэй байна.

Өнөөдрийн байдлаар УИХ-ын чуулганаар Зэвсэгт хүчний тухай хуульд дахин нэмэлт оруулахаар хуулийн төслийг хэлэлцүүлж байна. Энэхүү нэмэлтээр "Зэвсэгт хүчний хөгжлийн сан"-г Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан тусгай сангийн төрөлд хамааруулж, бүрдүүлэлт, зарцуулалтын онцлогтой холбогдсон харилцааг Зэвсэгт хүчний тухай хуулиар, нийтлэг харилцааг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулиар зохицуулах эрх зүйн зохицуулалтыг хийж байгаа.

Энэ хуульд нэмэлт оруулснаар Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийг улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтын ажилд оролцуулснаар Зэвсэгт хүчний хөгжлийн сангийн орлого нэмэгдэх шинэ эх үүсвэр бий болж, тодорхой хөрөнгө төвлөрүүлж, Зэвсэгт хүчний өмнө тулгамдаад байгаа зэвсэглэл, техникийн шинэчлэлийг хийх, бэлэн байдал, сургалт бэлтгэлийн түвшинг дээшлүүлэх, бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллын асуудлыг шийдвэрлэх боломж бүрдэх юм.

Мөн энэ онд Тагнуулын байгууллагын тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай, Газрын төлбөрийн тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулахаар төлөвлөөд байгаа. Мэдээж эдгээр нэмэлт өөрчлөлт оруулах хуулиудын төсөл нь Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний эрх зүйн орчинг улам боловсронгуй болгоход буюу Та бидний ажил үүрэг хуулийн дагуу явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдэнэ.

Цаашид "Монгол Улсын хууль, тогтоомжийг 2024 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-д Цэргийн албаны тухай, Энхийг дэмжих ажиллагаанд оролцох тухай, Дайны байдлын тухай зэрэг 10 орчим хуульд ирэх 4 жилд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгаад байна.

Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх дунд хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг болох "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024 он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр"-ийг ойрын хугацаанд Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн батлуулахаар ажиллаж байна. Удахгүй хөтөлбөр батлагдаж ирэх 4 жилд мэргэжлийн цэрэгт суурилсан, чадварлаг Зэвсэгт хүчнийг хөгжүүлж, бэхжүүлэх дунд хугацааны зорилго, зорилт, хүрэх үр дүн тодорхой болох юм.

Сайд миний сэтгэл хангалуун байгаа нэг асуудал бол 2020 онд ЗХЖШ Зэвсэгт хүчний стратегийн удирдлага, төлөвлөлтийн баримт бичгүүдийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Зэвсэгт хүчний Ерөнхий командлагч болон Батлан хамгаалахын сайдаар батлуулсан нь 2009 оноос хойш хүлээгдэж байсан энэхүү стратегийн төлөвлөлтийг зориглон боловсруулж, шийдвэрлүүлсэн чухал арга хэмжээ болсон юм.

Миний бие салбарынхаа гадаад харилцаа, хамтын ажиллагааг Зэвсэгт хүчний

хөгжилд бодитой өөрчлөлт, шинэчлэл хийх тийм л бодлогоор өргөжүүлэн хөгжүүлэх зорилт тавиад байна.

Үүний хүрээнд Монгол Улсад суугаа Элчин сайд нарыг хүлээн авч уулзан тухайн улс бүртэй хамтын ажиллагааг хэрхэн өргөжүүлэх талаар санал солилцож, Засгийн газрын болон Батлан хамгаалахын сайдын бодлого, зорилтын хүрээнд хамтран ажиллах чиглэлүүдээ тодорхойллоо.

2020 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн олон улсын болон хамтарсан сургууль, дадлагууд халдварт цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан ихэнх нь хэрэгжээгүйг Та бүхэн мэдэж байгаа. Гэсэн хэдий ч АНУ-ын тусгай хүчинтэй хамтарсан "Баланс мэжик-2020" тусгай хүчний хэргийн сургалт, дадлага, ХБНГУ-тай хамтарсан "Уулын явган цэргийн сургалт"-ыг эх орондоо амжилттай зохион байгуулж, ОХУ-тай хамтарсан "Сэлэнгэ-2020" тактикийн хэргийн сургуулийг 2 улсын нутаг дэвсгэрт нэгэн зэрэг явуулж, тус сургуулийн команд-штабын сургуульд Монгол Улсын Зэвсэгт хүчний төлөөллийг оролцууллаа.

Дэлхийг нөмөрсөн цар тахлын энэ хүнд цагт Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад үүрэг гүйцэтгэж байсан дайчид маань олноор коронавирусийн халдвар авсан тухай мэдээнд ихэд санаа зовж байлаа. Харин манай цэргийн багийн удирдлага, бие бүрэлдэхүүн сэтгэл зүйн өндөр чадвар, залуу хүний эрүүл, чанга бие бялдрын хүчээр энэхүү өвчнийг даван гарч чадлаа.

Саяхан Засгийн газрын 2021 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдаанаар 2021 онд энхийг дэмжих ажиллагаанд цэргийн баг, алба хаагчдыг оролцуулах болон олон улсын хамтарсан сургалт, дадлага зохион байгуулах асуудлыг шийдвэрлүүллээ.

Энэ онд Монгол Улсын Зэвсэгт хүчнээс Бүгд Найрамдах Өмнөд Судан Улс, Исламын Бүгд Найрамдах Афганистан Улсад явагдаж буй энхийг сахиулах болон олон улсын цэргийн ажиллагаанд цэргийн багууд, цэргийн ажиллагч, штабын офицер, ахлагчийг урьдын адил оролцуулна.

Харин 2020 онд дэлхий нийтэд тархсан цар тахлаас шалтгаалж олон улсын хамтарсан сургалт, дадлага явагдаагүй тул энэ жил "Ковид-19" халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч Монгол Улсад 14, гадаад улсад 5 олон улсын хамтарсан сургалт, дадлага зохион байгуулахаар төлөвлөсөн байгаа.

Мөн дээрх шийдвэрийн дагуу 2021 онд өөрийн оронд "Хааны эрэлд", "Баланс мэжик" зэрэг олон улсын сургалт, дадлага, "Аравт" олон улсын морин цэргийн уралдаан, тэмцээнийг зохион байгуулах бол гадаад улсад ОХУ-тай хамтарсан "Сэлэнгэ" хэргийн сургууль, "Танкийн биатлон" тэмцээнд Зэвсэгт хүчнээс алба хаагчийг оролцуулна.

Салбарынхаа шинжлэх ухаан, технологи, инновац, судалгаа, туршилтын ажлыг хөгжүүлэхэд онцгой анхаарах цаг ирсэн гэж бодож байгаа. "Алсын хараа-2050" урт хугацааны бодлогын баримт бичигт дэвшүүлсэн "Батлан хамгаалах тогтолцоог төгөлдөржүүлэн, технологийн дэвшлийг нэвтрүүлж, батлан хамгаалах аж үйлдвэрлэлийг хөгжүүлэх" зорилтыг хэрэгжүүлэх хүрээнд Батлан хамгаалах яам, Шинжлэх ухааны академи хооронд хамтран ажиллах санамж бичгийг өнгөрсөн онд байгуулсан.

Цэргийн шинжлэх ухаан, технологийн хөгжлийн чиг хандлагатай уялдуулан аюулгүй байдал, батлан хамгаалах эрх ашигт нийцсэн салбарын шинжлэх ухаан, технологи, инновац, судалгаа, туршилтын ажлыг хөгжүүлэх зорилгоор "Батлан хамгаалахын шинжлэх ухаан, технологи, инновац"ын 2021-2030 онд хөгжүүлэх бодлого" баримт бичгийг батлан хэрэгжүүлнэ. Энэхүү бодлогын баримт бичгийн үзэл санаа нь Монголын цэргийн шинжлэх ухаан, үндэсний цэргийн урлагийг хөгжүүлэх, бусад улсын дэвшилтэт технологийг инновац шингээх замаар нутагшуулах, цэргийн зэвсэглэл, техникийг дотооддоо үйлдвэрлэх үндэс суурийг бодитойгоор бүрдүүлж, бэхжүүлэхэд орших юм.

Дотооддоо алба хаагчдынхаа цэргийн эд хэрэглэл, зарим төрлийн цэргийн техник, хэрэгсэл, бага калибрын сумаа эхний ээлжинд дотооддоо үйлдвэрлэх нь бидний нэн тэргүүний зорилт юм.

2020 онд Зэвсэгт хүчний анги, байгууллагыг түшиглэн авто болон хуягт техникийн засвар, үйлчилгээ, туршилт, угсралт явуулах, радиостанц, радио электроникийн тоног төхөөрөмж, робот техник зохион бүтээх, туршилт судалгаа, угсралт явуулах, радиолокац болон радио техникийн засвар, үйлчилгээ, туршилт, судалгаа, хийх, программ, хангамж хөгжүүлэх, нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн туршилт, судалгаа, угсралт явуулах зэрэг техник технологи, инновац, туршилт, судалгаа, үйлдвэрлэлийн төвүүдийг бэхжүүлэх талаар тодорхой ажил, арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2020 онд Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн бие бүрэлдэхүүн төрөөс даалгасан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн 416.1 км шинэ төмөр замын бүтээн байгуулалтын ажилд оролцож, үүргээ маш сайн гүйцэтгэсэн. Ийм стратегийн томоохон

бүтээн байгуулалтын ажлыг мэргэжлийн чадварлаг бие бүрэлдэхүүнтэй, орчин үеийн өндөр хүчин чадал бүхий техник, тоног, төхөөрөмжөөр хангагдсан, зохион байгуулалттай манай барилга-инженерийн цэрэг л богино хугацаанд, чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэж чадах юм байна гэдгийг иргэд, аж ахуйн нэгж, нийгмээрээ хүлээн зөвшөөрч байна.

"Засгийн газрын 2020-2024 онд үйл ажиллагааны хөтөлбөрт алба хаагчдынхаа ажиллах, амьдрах нөхцөлийг сайжруулах талаар анхаарч ажиллана.

Өнгөрсөн онд 591 офицер, ахлагч, ахмад дайчид, ажилтан, алба хаагчдад амьдарч байгаа албан тушаалын байрыг нь нэн хөнгөлөлттэй үнээр болон үнэгүйгээр олгож, хувьчилж өглөө.

Энэ онд Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын барилга, байгууламжуудыг орчин үеийн инженерчлэлийн шийдэл бүхий "Жишиг цэргийн хотхон"-ы стандартад үе шаттайгаар нийцүүлэн шинэчлэх арга хэмжээг хэрэгжүүлж эхэлнэ.

Энэ нь бригадын түвшний хотхоны стандартаар Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийг; хорооны түвшний хотхоны стандартаар Зэвсэгт хүчний 123 дугаар ангийг, батальоны түвшний хотхоны стандартаар Зэвсэгт хүчний 234 дүгээр ангийг, жишиг хотхон болгон тохижуулахаар зорьж байна.

"Жишиг цэргийн хотхон"-ы стандартад нийцүүлэх ажлыг эхлүүлснээр цэргийн алба хаагчдын ажиллаж, амьдрах таатай орчин нөхцөл бүрдэж, нийгмийн хамгааллын тулгамдсан асуудлууд шийдвэрлэгдэх бөгөөд орчин үеийн барилга, байгууламжийн стандартад нийцсэн, цогц үйлчилгээг хангасан жишиг хотхонуудыг байгуулах ажлын суурь тавигдана гэж ойлгож болно. Энэ жишигээр цаашид Зэвсэгт хүчний бүх нэгтгэл, анги, салбар жишиг стандартад шилжинэ гэж ойлгох нь зүйтэй.

Батлан хамгаалах салбарын хэмжээнд хяналт шалгалтын үйл ажиллагаа явуулж байгаа Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн Ажлын алба, яамны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар, Зэвсэгт хүчний Хяналт шинжилгээ, үнэлгээний газрын алба хаагчидтай саяхан 1 дүгээр сарын 20-нд уулзаж хяналт шалгалтын тогтолцоог бэхжүүлэх, үр дүнг дээшлүүлэх, дотоод аудитын хорооны үйл ажиллагааг тогтмолжуулах, төсөв, санхүүгийн сахилга хариуцлагатай холбоотой зөрчил дутагдлыг арилгах, таслан зогсоох, харьяа төсөвт болон төрийн өмчит байгууллагуудын дотоод хяналтын үйл ажиллагааг сайжруулах, тэднийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх зөвлөмжөөр хангах зэргээр хяналт шалгалтын асуудлаар санал бодлоо солилцож, үүрэг чиглэл өгсөн.

Та бүхэнд батлан хамгаалах талаар 2020 онд бид юуг хийж амжуулав, цаашид хэрхэн ажиллах талаар товчхон байдлаар санал бодлоо хуваалцлаа.

Одоо Та бүхэнд 2021 онд ажил, албандаа анхаарч ажиллах үүрэг, чиглэлийг өгье. Ойн өмнөхөн ЗХЖШ-ын 2020 оны үйл ажиллагааны тайлангийн хуралд оролцох үеэр тодорхой үүргүүдийг өгсөн. Гэсэн хэдий ч өнөөдөр Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүн энд бүгд оролцож байгаа тул та бүхэндээ дахин анхаарал хандуулахыг хүсэж байна.

Мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг бүрдүүлж бэхжүүлэх зорилт нь төрлийн ба тусгай мэргэжлийн цэргийн нэгтгэл, анги нэг бүрийг тайван цагийн орон тоо, зохион байгуулалтаараа байлдааны үүрэг гүйцэтгэх чадвартай салбар, нэгжтэй болгохыг нөхцөлдүүлж байгаа юм. ЗХЖШ цэргийн нэгтгэл, ангиудыг тайван цагийн зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэхдээ үүнийг заавал харгалзаж үзэж байхыг чиглэл болгож байна.

Энэ удаагийн цугларалтаар "Цэргийн операцийг төлөвлөж явуулах арга зүй" сэдвээр зохион байгуулсан нь та нарт зөвхөн мэдээлэл өгөх гэсэн хэрэг огтхон ч биш гэж би ойлгож байна. Манай Зэвсэгт хүчний удирдах албаны генерал, офицер бүр тусгайлан бүрдүүлсэн цэргийн түр бүлэглэлээр цэргийн операц бэлтгэн явуулах онол, арга зүйн мэдлэг, дадлага, чадвартай байх ёстой. Энэ бол ЗХЖШ, төрлийн цэргийн штабын офицеруудад тэргүүн зэрэгт тавигдах шаардлага байх ёстой гэдгийг зориуд тэмдэглэж байна.

➤ Зэвсэгт хүчинд шинээр байгуулагдсан төрлийн цэргийг бэхжүүлэх, дүрмийг батлан, командлал бие дааж үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, эхнээс нь ул суурьтай хандаж үндэс суурийг зөв тавих нь зүйтэй.

➤ Өмнө үүрэг болгож байсан цэргийн сургалт бэлтгэлийн тогтолцоог шинэчлэх, сургалтын технологийг өөрчлөх ажлыг түргэтгэж, нийт бие бүрэлдэхүүний мэдлэг, дадлага, чадварыг нэмэгдүүлэх ажлыг гол зорилтоо болгож хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Түүн дотроо даргалах бүрэлдэхүүний стратеги, операц, тактикийн мэдлэгийг дээшлүүлэх, тухайн албан тушаалын үүргээ чадамгай гүйцэтгэх чадвар эзэмшүүлэхэд анхаарч сургалтын шинэ зэв маяг, арга, технологийг нэвтрүүлэх, тэдэнд өөрийгөө хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх нь чухал юм.

➤ "Зэвсэгт хүчний байгуулалтыг 2024

он хүртэл хөгжүүлэх хөтөлбөр" батлагдмагц, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг бодитойгоор, хэрэгжихүйц, үр дүнд суурилсан байдлаар боловсруулж 2021 оны эхний улиралд багтаан надаар батлуулж, түүнийг хэрэгжүүлэхэд онцгой анхаараарай.

➤ "Жишиг цэргийн хотхон" төслийг Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлээс хэрэгжүүлж эхэлнэ. ЗХЖШ, Хуурай замын цэргийн командлал энэ ажлыг хэрэгжүүлэхэд санаачилгатай ажиллаарай.

➤ Зэвсэгт хүчний алба хаагчдын ёс зүй, шударга байдал, сахилга хариуцлага, ажил албандаа хандах хандлагын талаар шат шатандаа онцгой анхаарч ажиллах хэрэгтэй. Батлан хамгаалах, Зэвсэгт хүчинд мөрдөгдөж буй хууль, дүрэм, ёс зүйн шаардлагуудыг тууштай, ягштал мөрдөж ажиллах нь салбарын хэмжээнд сахилга, хариуцлагыг дээшлүүлэхэд зогсохгүй, алба хаагчдын эрхэлсэн ажилдаа хандах хандлагыг өөрчлөхөд нэн чухал ач холбогдолтой.

➤ Цэргийн алба, цэргийн хөдөлмөрийн болон хөдөлгөөний аюулгүй байдалтай холбоотой осол, зөрчил буураагүй, улмаар цэргийн алба хаагч эрүүл мэндээрээ хохирох, амь насаа алдах тохиолдол гарсаар байна.

Энэ талаар БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалуудаас нэгтгэл, анги, байгууллагуудад өгсөн үүрэг, даалгавар, санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж чамлахааргүй олон байгаа ч, гагцхүү тэдгээрийг ажил хэрэг болгон үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, хэвшүүлэх бүх шатны захирагч, дарга, албан тушаалтнуудын ажлын хариуцлагыг дээшлүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих, дотоодын хяналт шалгалтын чанар, үр нөлөөг эрс сайжруулах, уг асуудалд цэргийн алба хаагч бүр ухамсартай хандахад онцгой анхаарч ажиллах шаардлагатай байна.

Бүх үйл ажиллагаа хууль, дүрмийн хүрээнд явагдах учиртай. Осол, зөрчил гаргасан хэн ч бай хариуцлага хүлээх учиртайг дахин сануулъя. Шат шатандаа анхаарах хэрэгтэй

➤ Монгол Улсын Их Хурал, Засгийн газраас "Ковид-19" цар тахлын үед улс орны эдийн засгийг дэмжих, төсвийн алдагдлыг бууруулах, гамшгийн өндөржүүлсэн болон бүх нийтийн бэлэн байдлын зоргуудад шилжсэн үед төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу, хэмнэлттэй зарцуулах, батлагдсан төсвийнхөө хүрээнд өмнөө тавигдсан зорилгоо биелүүлэх бодлого хэрэгжүүлж байгаатай уялдуулж, бүх шатанд төсвийн сахилга батыг чанд сахиж ажиллах үүрэг, хариуцлага та бидэнд зүй ёсоор тавигдаж байгаа. Үүсээд байгаа нөхцөл байдлаас шалтгаалан улсын хэмжээнд төсөв, санхүүгийн хүндрэл үүсэх, эдийн засгийн чадавч сулрах хандлагатай байна. Иймд батлагдсан төсвийн ангилал, зориулалтын дагуу, үр дүнтэй зарцуулах, төсвийн бодит хэмнэлт гаргахад анхаарч төсвийн үргүй зардлыг таслан зогсоох, өмнөх жилүүдэд өгөгдсөн зөвлөмж, акт, албан шаардлагын биелэлтийг ханган ажиллахыг үүрэг болгож байна.

➤ Энэ онд батлан хамгаалах яамны 110, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой тохионо. Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчний Жанжин штаб гээд шат шатандаа ойн хүрээнд нэлээдгүй ажлыг хийж хэрэгжүүлэхээр төлөвлөөд байгаа. Тэгэхээр та бүхэн төлөвлөгдсөн ажлуудаа ажил хэрэг болгох, ойг утга төгөлдөр, нийтэд хүртээмжтэй, өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлэхэд анхаарч, Зэвсэгт хүчний ойн баярыг эх орныхоо тусгаар тогтнол, эрх чөлөө, амгалан тайван амьдралыг бий болгоход оруулсан Зэвсэгт хүчний үе үеийн цэргийн зүтгэлтэн, цэргийн алба хаагчдын оруулсан хувь нэмрийг сурталчлах, залуучуудад эх оронч үзлийг төлөвшүүлэхэд чиглүүлэх нь зүйтэй.

2021 он манай салбарын хувьд өндөр хариуцлага, ажлын их бүтээл шаардсан жил болно гэж Би харж байгаа.

Батлан хамгаалах яамнаас 2021 оны үйл ажиллагааны зорилгыг "Батлан хамгаалахын эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, төрийн захиргааны удирдлагын манлайлыг хангах үндсэн дээр улс орныг батлан хамгаалах тогтолцоог бүрдүүлж, төлөвшүүлэх, мэргэжлийн цэрэгт суурилсан Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх дунд хугацааны бодлого, төлөвлөлтийн хэрэгжилтийг хангана" гэж тодорхойлоод байна.

Иймд төр, засгийн бодлогыг бүхий л шатандаа хэрэгжүүлэхийн төлөө ажил албаа төлөвлөж, 2021 онд дэвшүүлсэн зорилго, зорилтуудаа шат, шатандаа бүрэн дүүрэн хангаж ажиллана гэдэгт итгэл төгс байгаагаа хэлье.

Эцэст нь энэ цаг үед Монгол Улсынхаа Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний хөгжил, цэцэглэлт, цаашдын сайн сайхны төлөө бие сэтгэлээ зориулан мөр зэрэгцэн зүтгэж байгаа БХЯ, ЗХЖШ, Төрлийн цэргийн командлалууд, цэргийн нэгтгэл, анги, салбар, харьяа байгууллагуудынхаа удирдлага Та бүхэнд болон салбарынхаа нийт бие бүрэлдэхүүнд эрүүл энх, амжилт бүтээлээр дүүрэн байхын өлзийтэй ерөөлийг дэвшүүлнэ.

М.Эрдэнэдалай: ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ АР ТАЛ ГЭДЭГ ЯЛАЛТЫН ҮНДЭС ЮМ

ЗХЖШ-ын Материал техникийн газрын дарга, бригадын генерал М.ЭРДЭНЭДАЛАЙ

Энэ жил Зэвсэгт хүчний 100 жилийн түүхэн ой тохиохын зэрэгцээ Зэвсэгт хүчний Ар тал үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ой тохиож байна. Та Зэвсэгт хүчний ар тал гэдгийг тодорхойлж, ямар чиглэл үүрэгтэй байдаг талаар уншигчдадаа товчхон танилцуулахгүй юу?

-Зэвсэгт хүчний ар тал гэдэг нь Зэвсэгт хүчний амжилтад голлох үүрэг гүйцэтгэдэг, тэр хэрээрээ хариуцлага үүрдэг Зэвсэгт хүчний томоохон нэгж юм. Сүүлийн хэдэн зууны дайн, зэвсэгт мөргөлдөөний дүнд "Хэн ар талаа хамгаалж чадна, тэр дайнд ялж чадна" гэсэн үг хүртэл гарч байсан. Энэ нь орчин үеийн дайн, зэвсэгт мөргөлдөөнд ар тал гэдэг бол ялалтын үндэс юм гэдгийг илэрхийлэх тод жишээ юм. Оросын алдарт жанжин А.А.Брусилов "Бүх дарга нарын хамгийн эхний үүрэг бол цэргийг халамжлах явдал юм" гэж хэлсэн байдаг. Энэ үгний "цэргийг халамжлах" гэдэг нь цэргийн бүх төрлийн хангалтыг тасралтгүй зохион байгуулах явдал гэсэн санаа юм.

Мөн Алтан ордны улсын хаан Бэрх "Хангалтгүй цэрэг, хяналтгүй дээрэмчин болж хувирдаг" гэсэн байдаг. Энэ үгний үндэс нь хоол хүнс зэрэг ар талын хангалт нь цэрэг армийн сахилга бат, зохион байгуулалтын үндэс болдог гэсэн үг. Өлсгөлөн цэрэг хоол олж идэхийн тулд дээрэм тонуул хийж цэргийн сахилга бат, дэг журам, зохион байгуулалтыг алдагдуулах аюултай гэдгийг тодорхой харуулсан байна. Энэ нь ар талын хангалтын мөн чанарыг ойлгуулсан гайхалтай үг. Эдгээр үгс Зэвсэгт хүчний ар талын үүргийн үндсэн ухагдахууныг харуулж байгаа юм. Тэгэхээр Зэвсэгт хүчний ар тал гэдэг бол Зэвсэгт хүчний амин судас нь.

Өнгөрсөн 100 жилийн түүхэнд ар талын хангалтыг бэхжүүлэх, хөгжүүлэх үйлсэд ар талын хангалтын мянга мянган дайчид хичээн зүтгэж байсан, одоо ч хичээн зүтгэж байна, цаашид ч зүтгэх болно. Би тэднийгээ Зэвсэгт хүчний үндсэн үүргээ биелүүлэхэд бүх талын нөхцөлийг бүрдүүлж яваа арын фронтын шилдэг дайчид, их бүтээлийн эзэд гэж боддог. Тиймээс би Зэвсэгт хүчний ар талын хангалтын үйл ажиллагаанд сэтгэл зүрхээ зориулан зүтгэж яваа үе үеийн ахмад дайчид болон мөр зэрэгцэн зүтгэж яваа эрхэм дайчин нөхөдөө, албан хаагчдадаа "Та бүхнээрээ үргэлж бахархаж явдаг" гэдгээ ярилцлагынхаа эхэнд хэлмээр байна.

Хүн төрөлхтөн гурван цагийн хэлхээнд амьдардаг. Энэ нь өнгөрснөөсөө сургаж авч одоог бий болгох, одоогоо улам боловсруулж болгож ирээдүйгээ төгөлдөржүүлэх, сайн сайхан байлгахад оршдог. Хийж, бүтээх үйлс, сэтгэл зүрхээ эх орныхоо, Зэвсэгт хүчнийхээ хөгжлийн төлөө зориулсан Зэвсэгт хүчний үе үеийн дайчдадаа ч мөн энэ эрхэм алдар гавьяа, амжилт бүтээлийн 100 жилийн ойн мэндийг хүргэж амжилт бүтээлийг хүсэн ерөөе.

Танд маш их баярлалаа. Зэвсэгт хүчний ар талыг бэхжүүлэх, хөгжүүлэх их үйлсэд гаргасан 100 жилийн амжилт бүтээл бүхнийг дурсан ярина гэдэг хэдэн мянган хуудас ч багадна. Тэгэхээр та Зэвсэгт хүчний ар талын амжилт бүтээлийг багцлаад хэдхэн өгүүлбэрт багтаагаад хэлж болох уу? Яагаад гэхээр Зэвсэгт хүчний Ар тал гэдэг том айл дотор нь ажиллаж, амьдарсан, дэслэгчээсээ генералаа хүртэл хэлж чадна гэж бодож байна.

-Зэвсэгт хүчний ар тал гэдэг энэ том айлын хийж бүтээсэн, хөгжүүлж дээшлүүлсэн, сайжруулж санаачилсан гээд урьд хийж бүтээсэнээ, хийж хэрэгжүүлж байгаагаа, хийхээр төлөвлөн ажиллаж байгаагаа яривал маш их цаг зав зарцуулна. Товчдоо

бол, Зэвсэгт хүчний ар тал 100 жилийн тэртээд Ардын журамт цэргийн нэг эд эс болон үүсэн хөгжиж эхэлснээс эхлээд 1921 оны Ардын хувьсгал, Халхын голын дайн, Чөлөөлөх дайн, Баруун хилийн зэвсэгт тулгаралт гээд хүнд он жилүүд, мөн Зэвсэгт хүчний өргөтгөн зохион байгуулж, Мотомеханикуулсан армийг байгуулах гээд бүхий л цаг үед үүргээ нэр төртэй биелүүлсээр ирснийг түүх гэрчилнэ. Мөн өнгөрсөн зууны сүүлээр эхэлсэн нийгмийн өөрчлөлтийн хүнд цаг үеийг даван туулж, армийг шинэ үеийн зорилго, зорилтод нийцүүлэн орчин үеийн Зэвсэгт хүчин болгон хөгжүүлэх, өнөөдрийн энэ амжилт бүтээлд хүргэсэн нь үе үеийн ахмадуудын маань цуцалтгүй нөр их хөдөлмөр, хичээл зүтгэлийн үр дүн байсан гэдгийг түүхт 100 жилийн босгон дээр тэмдэглэн хэлэхэд таатай байна.

Та сүүлийн үед хэрэгжүүлж байгаа Зэвсэгт хүчний ар талын үйл ажиллагааны зорилго, чиглэл, түүний хэрэгжилттэй холбоотой ямар мэдээлэл өгөх вэ?

-Манай хамт олон түүхт ойгоо эртнээс угтаж томоохон зорилго, зорилтуудыг дэвшүүлж, материал, техникийн хангалтын тогтолцоог боловсронгуй болгох, цэргийн сургалт бэлтгэлийг хэвийн явуулахад шаардагдах материал, техникийн бүх төрлийн хангалт үйлчилгээг тасралтгүй явуулах, ажиллаж, амьдрах аятай орчныг бүрдүүлэх, бие бүрэлдэхүүний нийгмийн зарим асуудлыг шийдвэрлэхэд ажлаа чиглүүлж, багагүй арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлжээ. Тэдгээрээс гухасхан дурдахад, Засгийн газрын 2020 оны мн/99 дүгээр тогтоол, Батлан хамгаалахын сайд, ЗХЖШ-ын даргын тушаалуудыг үндэслэн Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн харьяанд үүрэг гүйцэтгэж байсан "Галт хэрэглэл аюулгүй болгох тусгай байгууламж" /М/ байгууламж"-ийг Зэвсэгт хүчний 334 дүгээр анги болгон өргөтгөн зохион байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлсэн.

Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх, сэргээн сайжруулах ажлын хүрээнд одоо ашиглаж байгаа зэвсэглэл, цэргийн техникийг дэвшилтэт технологи нэвтрүүлж ашиглах, цэргийн техникийн зарим эд анги, сэлбэг хэрэгслийг дотооддоо үйлдвэрлэх чадавхтай батлан хамгаалах аж үйлдвэрийн суурийг тавих, энхийг дэмжих ажиллагаанд болон улсыг хөгжүүлэх бүтээн байгуулалтад үүрэг гүйцэтгэх чадавхыг дээшлүүлэх зорилгоор "Зэвсэгт хүчнийг хөгжүүлэх, зэвсэглэл, цэргийн техникийг шинэчлэх хөтөлбөр"-ийн төсөл, холбогдох танилцуулга, санал тооцоог боловсруулж БХЯ-нд хүргүүлсэн.

Зэвсэглэл, цэргийн техникт сайжруулалт, хөгжүүлэлт хийх ажлууд эхнээсээ амжилттай хэрэгжиж эхлээд байна. Жишээ нь, АКМ загварын хүн нэг бүрийн зэвсэгт хийсэн сайжруулалт, "Багги", "Мазаалай" гэсэн нэр бүхий хөнгөн хуягласан автомашины зохион бүтээлт, хөгжүүлэлт, сайжруулалтын ажлыг дурдах нь зүйтэй юм. Дээрх ажлууд нь Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийн бэлэн байдлыг хангахад гадна өөрсдөө хийж бүтээх боломжийг нээж өгсөн, үндэсний гэх тодотголтой зэвсэглэл, цэргийн техникт сайжруулалт хийх чадвартай бие бүрэлдэхүүн, үйлдвэрлэл, зохион бүтээх суурь нөхцөлийг бүрдүүлэх, бий болгох нь бидний үүрэг болж байгааг харуулсан явдал юм.

Түүнчлэн сүүлийн жилүүдэд Зэвсэгт хүчний авто, хуягт танкийн техникт сэргээн сайжруулах засвар, үйлчилгээг батлагдсан төсвийн хүрээнд зохицуулалт хийх замаар шийдэх, нэлээд олон нэгтгэл, анги, байгууллагын техникийг хамруулан гүйцэтгэлээ. Энэ нь Зэвсэгт хүчний ТЦОТ-ны болон дайны цагийн орон тооны зэвсэглэл, цэргийн техникийн

бэлэн байдлыг үе шаттайгаар хангаж байгаа үр дүнтэй ажлуудын нэг болсон. 2018 онд ЗХЖШ-ын даргын тушаалаар сүүлийн жилүүдэд тасраад байсан Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбаруудын зэвсэглэл, цэргийн техник, ар талын табель хэрэгсэл, хэмжил зүйн багаж хэрэгслийн нэгдсэн тооллого,



үзлэг явуулж, хадгалалт, арчлан хамгаалалтын чанар байдалд үнэлэлт дүгнэлт хийж, Зэвсэгт хүчний зэвсэглэл, цэргийн техникийн бэлэн байдлын түвшинг тогтоох, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон үр дүнтэй ажил болсон.

Материал хэрэгслийн халдашгүй нөөцийг оновчтой байршуулах, бүрдүүлэх чиглэлээр стратегийн төлөвлөлтийн, сольж шинэчлэх ажлыг урсгал хангалтын хэрэгцээгээр төлөвлөн хэрэгжүүлж, хүнс, хуурай хэрэглэл хадгалах агуулахыг шинээр барьж ашиглалтад оруулснаар Улаанбаатар цэргийн хүрээний нэгтгэл, ангиудын хэрэгцээт мах, махан бүтээгдэхүүний 30-90 хоногийн хэрэгцээг хадгалах нөхцөлийг бүрдүүлсэн. Нөөцийн малын тоог нэмэгдүүлэх бодлого боловсруулж ажилласнаар халдашгүй нөөцийн малын тоо, толгой тодорхой хувиар өслөө. 2021 онд манай хамт олон "Зэвсэгт хүчний байгуулалтыг хөгжүүлэх хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган, Зэвсэгт хүчний материал, техникийн хангалтын үүрэг гүйцэтгэх чадавх, бэлэн байдлын түвшинг дээшлүүлэх" зорилго дэвшүүлж дараах ажил, арга хэмжээнүүдийг төлөвлөн хэрэгжүүлж эхлээд байна.

Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.3.4-т, 2018 оны 400 дугаар тогтоолоор батлагдсан "Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр"-ийн хэрэгжилтийг Зэвсэгт хүчинд хангах зорилго тавьж, "Махны чиглэлийн эрчимжсэн үхрийн аж ахуй" төслийг боловсруулан энэ онд ЗХЖШ-ын даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан. Мөн бие бүрэлдэхүүний нийгмийн хамгааллыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлд Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн харьяа "Найман шарга" амралтын газрын үйл ажиллагааг өргөжүүлж, жилийн тойрон амрагчдыг хүлээн авах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Найман шарга-4 улиралд" төслийг боловсруулж, бэлтгэлээ хангаж байна.

Цэргийн алба хаагчдын үндсэн болон тусгай хувцас, хамгаалах хэрэгслийн загвар, материалын өнгө, чанар байдалд физик газар зүй, улирал, цаг агаар, үүрэг гүйцэтгэх онцлогт тохируулан, өнгө загварын өөрчлөлтийг хийж, хувцас хэрэглэлийн нормыг шинэчлэн батлуулсан. Үүний зэрэгцээ сүүлийн жилүүдэд нэлээд орхигдоод байсан зэвсэглэл, цэргийн техник, ар талын табель хэрэгслийн бэлэн байдлыг хангах үүрэгтэй хэмжил зүйн

албыг шинээр газрын бүтцэд оруулж, үйл ажиллагааг нь эхлүүллээ. Хэмжил зүйн албаны үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлж Зэвсэгт хүчний хэмжил зүйн дүрэм, журам, заавар зэрэг удирдлагын баримт бичгийг боловсруулж Батлан хамгаалахын сайд болон ЗХЖШ-ын даргын тушаалаар

техникийн хангалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн "Шинэ бүтээл, оновчтой санаа", "Шилдэг ном, гарын авлага" шалгаруулах уралдаан, Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүний дунд "Материал, техникийн хангалт, ирээдүүд" сэдвээр эсэе бичлэгийн болзолт уралдааныг зарлахаас гадна 4 дүгээр сарын эхээр "Зэвсэгт хүчний Ар тал-100" сэдвээр эрдэм, шинжилгээний бага хурлыг зохион байгуулна. Мөн "Зэвсэгт хүчний ар тал-100" материал, техникийн мэргэжлийн цогцолбор тэмцээний хүрээнд "Танкийн биатлон-2021", "Авто засварын мастер-2021", "Зэвсгийн мастер-2021", "Материал хангалтын шилдэг офицер-2021", "Шилдэг тогооч-2021" зэрэг мэргэжлийн тэмцээнийг зохион байгуулахаар төлөвлөсөн. Энэ дашрамд дурдахад манай газрын мэргэжлийн хэлтсүүд өөр өөрсдийн мэргэжлийн тэмцээнийг жил бүр зохион байгуулж хэвшээд байна. Үүгээрээ дамжуулан мэргэжлийнхээ онцлогийг Зэвсэгт хүчинд сурталчлах, мэргэжлээрээ бахархаж, ажилдаа дур сонирхолтой болгох сайн талтай бөгөөд тэмцээнээр дамжуулан мэргэжлийн боловсон хүчний дадлага, үр чадварыг дээшлүүлэх, өндөр дадлага, үр чадвартай бүрэлдэхүүний нөөцийг бүрдүүлэх зэрэг ач холбогдол агуулагдаж байдаг үр дүнтэй ажил болдог.

Харьяа ангиудын дунд спортын цогцолбор уралдаан тэмцээнийг үе шаттайгаар зохион байгуулах, "Соёмбо" сониноор дамжуулан Зэвсэгт хүчний ар тал хэмээх өнөр бүлд багтаж, олон амжилт бүтээлийн зээн болсон хөдөлмөрч, үр чадвар сайтай, дадлага туршлагатай тэргүүний офицер, ахлагч, ажилтан албан хаагчаар ажиллаж байсан ахмадуудыгаа сурталчлан таниулах, туршлагыг түгээх, хойч үедээ тээн өвлүүлэх зорилгоор цуврал хөрөг, нийтлэлүүдийг хэвлүүлэх, "Зэвсэгт хүчний Ар тал-100" баримтат киног бүтээхээр төлөвлөн ажиллаж байна.

Энэ оны 9 дүгээр сард "Материал, техникийн газар, харьяа ангиудын нэгдсэн команд штабын сургууль болон тусгай тактикийн хэрийн сургуулийг нэгдсэн бодлого-төлөвлөгөөгөөр төлөвлөн явуулснаар Зэвсэгт хүчний материал, техникийн хангалтын нэгжүүдийн үүрэг гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх, бэлэн байдлын түвшинг дээшлүүлэхэд түлхэц болох юм. Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүндээ газрын харьяа ангиудын хийж бүтээсэн шинэ бүтээлийн дээсжийг харуулсан "Бүтээлийн үзэсгэлэн"-г мөн зохион байгуулна.

Ингээд ярилцлагынхаа төгсгөлд танд сэтгэлийнхээ үгийг нийт бүрэлдэхүүндээ хандаж хэлэх боломж олгоё.

-Энэ жил бол түүхэн жил. Монгол Улсад Батлан хамгаалах яам байгуулагдсаны 110 жил, Зэвсэгт хүчин үүссэний 100 жил, Зэвсэгт хүчний Ар талын 100 жилийн ой, газрын харьяа Зэвсэгт хүчний ууган ангиудын нэг, жанжин Д.Сүхбаатарын шууд санаачилгаар байгуулагдсан Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн 100 жилийн ой зэрэг түүхэн үйл явдлыг хөдөлмөр бүтээлээрээ мялааж, бэлэг барих боломж бидэнд олдож байна. Эдгээр ойг тэмдэглээд өнгөрөх биш, ойн хүрээнд тулгамдаж буй олон асуудлыг оновчтой, цаг мөч бүртэй уралдан шийдвэрлэх боломж гэж манай хамт олон харж байгаа.

Зэвсэгт хүчний Ар талын түүхийг бичилцэж, ар талын бүх төрлийн хангалтыг тасралтгүй, найдвартай зохион байгуулахын төлөө залуу халуун нас, өөрийн ухамсарт үйл ажиллагаа, хичээл зүтгэлээ зориулсан үе үеийн ахмадууд, мэргэжлийн Зэвсэгт хүчнийг цогцлоох, хөгжүүлэх үйлсэд зүтгэж байгаа Зэвсэгт хүчний нийт бие бүрэлдэхүүндээ түүхт 100 жилийн гал цогтой халуун мэндийг дэвшүүлж, та бүхэнд эрүүл энх, сайн сайхны дээдийг хүсэн ерөөе.

ИХ ЖАНЖИН Д.СҮХБААТАРЫН

Д.Сүхбаатар хэмээх түүхэн хүний талаар олон эрдэмтэн судалгаа, шинжилгээний бүтээл гаргаж байсан ч найман настай балчираас 80 хол давсан буурал боллоо зөвхөн тэр л хүний ертөнцөөр "амьсгалж", гавьяат үйлсээр нь бусдад "цэцэрхэж" ирсэн эрхэм бол О.Баатар юм. Их жанжны мэндэлсэн түүхэн өдрийг тохиолдуулан түүнтэй хэсэг саатаж ярилцлаа.

О.Баатар: ЖАНЖНЫ ХЭЛСЭН ҮГС АМЬДРАЛЫН МИНЬ ФИЛОСОФИ БОЛСОН



Анх хэзээнээс Д.Сүхбаатар жанжны талаар судлах болов? Ямар шалтгаанаар таны сонирхлыг татсан бэ?

-Би эрдэмтэн судлаач биш. Зүгээр л Д.Сүхбаатар жанжны талаар судалдаг энгийн нэг жолооч. Чухам яагаад энэ хүнийг бүхий л амьдралынхаа турш судалж, энэ хүнтэй холбоотой зүйлсийг цуглуулдаг болсон талаар олон хүн асууж сонирхдог. Энэ их сонин тохиолдол. Би Улаанбаатар хотын дагуул хот Амгаланбаатарт 1935 онд төрсөн. Энэ хот өнөөгийн Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн оршиж байлаа. 1921 оны сүүлчээр Жанжин Д.Сүхбаатар "Манай оронд ямар нэгэн соёл, урлагийн байгууллага зайлшгүй хэрэгтэй" гэсэн урилгыг залуучуудын дунд гаргаж. Урилгад нэгдсэн хэдэн залуус жанжны төрсөн газар хаана байгааг тодруулаад, 1923 оны эхээр буурь хавьцаа нь Монгол орны соёл, урлагийн байгууллагын анхных хэмээн нэрлэгддэг "Жанжин" клубыг байгуулсан байдаг.

Намайг найман настай байхад буюу 1943 оны хавар клубын тааз нурснаас болж ямар нэгэн үйл ажиллагаа явуулах боломжгүй болж. Тухайн үеийн урлаг, соёлын зүтгэлтнүүд "Жанжин" клубээ дахин сэргээхээр болоход ээж маань намайг барилгын ажилд тусуулахаар дагуулан очсон юм. Найман настай хэдий ч сайн дураараа тоосго, ус, шороо зөөх зэргээр чадлаараа туслав. Олны хүч оломгүй далай гэгчээр жил орчмын дараа шинэхэн клуб байгуулагдан баярын хурлаа хийлээ. Тэр хуралд барилгын ажилд оролцсон бүх хүнийг урьж оролцуулан шагнал гардуулахаар болов. Гэтэл тайзан дээрээс тухайн үед "Жанжин" клубын орлогч даргаар ажиллаж байсан найруулагч н.Тэрбиш гуай "Очирын Наваан" хэмээн миний нэрийг дуудаж байна. Би ч яваад очив. "Наваан гэдэг хүү мөн үү" гэж байна. Би "Мөн" л гэлээ. Тэгтэл н.Тэрбиш гуай "Наваан хүү бол "Жанжин" клубыг барих ажилд маш их тус хүргэсэн манай хамгийн бяцхан ажилчин. Тиймээс энэ хүүд Д.Сүхбаатар Жанжны Баатар хэмээх нэрийг өгье" гэлээ. Ийнхүү тэр өдрөөс хойш миний нэр О.Наваан биш О.Баатар болсон түүхтэй. Энэ явдлын дараагаас аав ээж хоёр минь надад жанжин Д.Сүхбаатар гэж хэн болох, манай улсын түүхэнд ямар гавьяа байгуулсан талаар хэлж, зааж захидаг болсон. Ингэж л энэ гавьяатай хүний нэрийг хэзээ ч

сэвтүүлж болохгүй юм байна гэсэн бодол төрж, үргэлж бахархаж, насан туршдаа түүний талаар судалж, сонирхож явах том сэжим эхэлсэн юм.

Таныг жанжны ажил амьдралтай холбогдолтой цуглуулгуудаар олон удаагийн үзэсгэлэн гаргасан гэж сонссон?

-Намайг багад Амгаланбаатарын айлуудад Д.Сүхбаатар, К.Е.Ворошилов нарын хөрөг болон гэрэл зураг, цээж баримал маш их байсан. Би нэгт л жанжны талаар сонирхох болсон тул тэр хүнтэй холбоотой цуглуулгатай больё гэж бодоод хөрөг, гэрэл зураг, марк, тэмдэг, сонин, сэтгүүлийн хайчлалбар, ном, товхимол зэргийг цуглуулж эхэлсэн. Нас биед хүрэх үед цуглуулга маань ч өргөжсөөр байв. Тухайн үед миний ганц зорилго Их жанжны гавьяат үйлсийг залууст аль болох сурталчлан таниулах байсан учир цуглуулгаараа үзэсгэлэн гаргавал яадаг бол гэсэн бодол гэнэтхэн төрөв. Тэгээд үзэсгэлэнгээ гаргачих санаатай Д.Сүхбаатарын нэрэмжит II сургуульд очиж захирал н.Жамбааняндаг гэдэг хүнтэй уулзан санаагаа хэллээ.

Сургуулийн захирал миний санааг туйлын баяртай хүлээж аваад бүх талаар дэмжинэ гэв. Дараахан нь би тэр сургуулийн нэг танхимд "Сүхбаатарчууд" гэсэн ганцтай нэлээн том ханын сонин гаргаад, 4-5 гэрэл зураг наагаад хэдэн хүүхдүүд тойруулж суулган тайлбарлаж өгье гэсэн бодолтой танхимын үүдээр орлоо. Гэтэл юун хэдэн хүүхэд байтугай бүх сургагч жагсчихсан, Д.Сүхбаатарын тухай "Туг" дууг дуулж, тэр ч байтугай тангараг өргөж намайг хүлээн авсан. Би ч ёстой цочирдож гайхшрахын зэрэгцээ хүүхдүүдэд ханын сонингоо муухан тайлбарлаж байснаа санадаг юм. Ийн анхны үзэсгэлэнгээ амжилттай гаргасан түүхтэй. Энэ үйл явдал надад маш их урам зориг өгч цаашид цуглуулгаа өргөжүүлэхэд хамгийн том тулах цэг болсон юм.

Дараа жилээс нь "Жанжин" клубт Их жанжны мэндэлсний 100 жил буюу 1993 он хүртэлх хугацаанд олон жил үзэсгэлэнгээ гаргасан. Түүний дараа Үндэсний түүхийн музей, Байгалийн түүхийн музей, Улаанбаатар хотын музей, Цэргийн төв музей, Хүүхдийн урлан бүтээх төв, Батлан хамгаалахын их сургууль, Н.Янжмаагийн нэрэмжит 19 дүгээр цэцэрлэг, Тусгаар тогтнолын ордон зэрэг газарт үзэсгэлэнгээ гаргаж байсан. Сүүлд тоолоод үзэхэд 54 жилийн

хугацаанд 70 орчим удаагийн үзэсгэлэн гаргажээ. Тэгэхдээ үзэсгэлэн гаргаад өнгөрөх биш, Их жанжны талаар эрдэмтэн судлаачдын бичсэн 120 орчим бүтээл байдгийг нэг бүрчлэн уншиж, дүн шинжилгээ хийсний үндсэнд цуглуулгаа тайлбарладаг болсон. Одоо нас өндөр болсон тул цуглуулгаа МАН-д өвлүүлэн үлдээсэн. Тусгаар тогтнолын ордонд миний цуглуулсан 500 орчим зүйл хадгалагдаж байна.

Хамгийн үнэ цэнтэй цуглуулга тань юу вэ?

Сүүлд тоолоод үзэхэд 54 жилийн хугацаанд 70 орчим удаагийн үзэсгэлэн гаргажээ. Тэгэхдээ үзэсгэлэн гаргаад өнгөрөх биш, Их жанжны талаар эрдэмтэн судлаачдын бичсэн 120 орчим бүтээл байдгийг нэг бүрчлэн уншиж, дүн шинжилгээ хийсний үндсэнд цуглуулгаа тайлбарладаг болсон. Одоо миний нас өндөр болсон тул цуглуулгаа МАН-д өвлүүлэн үлдээсэн. Тусгаар тогтнолын ордонд миний цуглуулсан 500 орчим зүйл хадгалагдаж байна.

-Миний цуглуулсан бүхэн надад үнэ цэнтэй. Түүхэн ач холбогдол талаас нь авч үзвэл "Марзан" Б.Шарав зураачийн 1930 онд тэмдэглэлийн дэвтэртээ зурсан Д.Сүхбаатарын хөрөг байна. Тэр зургийг БНМАУ-ын Ардын жүжигчин Ж.Данзангийн хүү барималчин Д.Тамсаг жижиг хэлбэрээр урласан байдаг. Миний цуглуулгад энэ хоёр бүтээл хоёулаа байдаг гэдгээрээ онцлог. Дээрээс нь гэрэл зураг гэдэг тэр чигээрээ түүх болж үлддэг. Тиймээс би хэд хэдэн ховор гэрэл зургийг цуглуулсан. Жишээ нь, Хүүхэд залуучуудын театрын зураач Л.Хатанбаатар гэдэг хүн надад өмнө нь огт харж байгаагүй Д.Сүхбаатарын залуу үеийн нэг зургийг өгсөн. Би гайхаад хаанаас тэр зургийг олсон талаар асуухад тэр зураачийн аав нь олон жил хадгалж явсан гэдгийг хэлсэн. Хачирхалтай нь тэрхүү зурган дээрх Д.Сүхбаатараас бусад хүнийг танихгүй учир тэр зургад тайлбар хийж чадаагүй. Хүмүүс аав, ээжтэйгээ хамт авахуулсан мэтээр тайлбарладаг. Яг үнэндээ би тэдгээр хүмүүсийг Их жанжны эцэг, эх гэдэгт эргэлздэг маань одоо ч хэвээр.

Монголын ард түмэн Д.Сүхбаатарыг гэдэг хүнийг голдуу

"Өглөө", "Мандах нарны туяа", "Сүхбаатар" зэрэг хуучны уран сайхны киноны дүрээр төсөөлдөг. Та Их жанжны судалдаг судлаачийн хувьд энэ хүний бий болгосон түүхийг юу гэж хардаг вэ?

-Энэ хүний Монгол Улсын түүхэнд оруулсан хувь нэмрийг хэмжээлшгүй гэж дүгнэдэг. Судлаачид энэ хүний талаар өөр өөрийн байр суурьтай байдаг. Миний хувьд Л.Бат-Очир, Ш.Нацагдорж нарын эрдэмтдийн бичсэн бүтээлүүдтэй санал илүү нийлдэг. Эх орныхоо түүхэнд оруулсан хувь нэмрийг нь дүгнэж хэлэхэд Д.Сүхбаатар бол монголчуудын сэтгэлгээний цонх нь болж хувьсгалт тэмцлийг эхлүүлсэн, олон залуусыг удирдаж үндэстнийхээ эрх ашгийг хамгаалж чадсан түүхэн зүтгэлтэн гэдгээс гадна бие бялдар, сэтгэл санаа, ухаан бодол, зориг тэвчээр зэргээрээ түмнээс шалгарсан, жинхэнэ төрмөл удирдагч байжээ гэж би шүтэж үздэг. Эх оронч зан чанар нь түүний хэлсэн үгсээс тод харагддаг. Жишээ нь, тэрээр нас барахынхаа өмнө "Эрхэм нөхөд та бүхэн одоогийн явуулан буй намын бодлого ба засгийн хэрэг явдлыг уг зорилгод нийлүүлж, ард түмний эрх чөлөөг мандуулж, аливаа дотоод, гадаадын эзэрхэг харгисуудын савраас ангижруулан ард түмнийг асран хамгаалах гэгээн замыг удирдан жолоодохыг эрхэмлэ! Миний бие алтан амийг алдавч ариун санаат нөхөд минь залгамжилж, элдэвт хичээн зүтгэж ардын төрийг мандуул" гэж хэлсэн байдаг. Тэгэхээр Д.Сүхбаатар ч биш, тэр үеийн монголчуудын үзэл санаа ямар нэгдмэл, ямар нөхөрсөг, ямар эх оронч байсныг энэхүү үгнээс харж болно.

С.Галсан гэдэг хүнтэй би анх 1966 онд танилцаж байлаа. Тухайн үед том биетэй, зан чанарын хувьд сэргэлэн хүн байсан санагдаж байна. Намайг аавынх нь талаар үзэсгэлэн гаргаж байгааг дуулаад гэртээ урилаа. Би ч санаа зовоод очиж чадсангүй. Хэдэн жилийн дараа цагаан сараар гэрт нь хадаг бариад очсон. Чухам тэр цагаас эхлэн С.Галсан гэдэг хүнтэй их л ойр дотно болцгоосон. Тухайн үед Жанжны үхлийн талаар судлаачид янз бүрийн таамаглал гаргаж байсан. Би зориг гаргаад С.Галсан гуайгаас Жанжны үхлийн талаар асуулаа. Тэгсэн бодолхийлж байснаа "Аав минь нас бардаг өдөр Элбэгдорж Ринчино гэдэг буриад хүн аавтай хагас цаг орчим хамт байсан. Гэрийн гадаа орос цэрэг харуулд гарч байсныг санаж байна. Элбэгдорж Ринчино гэрээс гарсны дараа 20-иод минут өнгөрөхөд аав минь нас барсан. Тиймээс хор өгсөн хүн нь тэр буриадыг гэж бодож байна" хэмээн хэлсэн удаатай. Надад хувийн таамаглал байхгүй ч төрсөн хүүгийн нь хэлсэн тэр үгийг үнэний ортой гэж боддог.

Монголын түүхийн хамгийн эгзэгтэй мөчид ард олны дундаас шалгаран гарч ирсэн нэрт удирдагч хүн Д.Сүхбаатар яах аргагүй мөн. Гэтэл түүнийг зохиомол мэтээр ярьдаг, намтар түүхийг нь гуйвуулагч хүмүүс мэр сэр байх юм. Олон жил судалсан хүний хувьд ямар тайлбар өгөх вэ?

-Жанжинтай холбоотой олон худал гүтгэлэг гарсан. Д.Сүхбаатар бол буриад хүн байсан мэтээр ярьдаг хүмүүс хэд хэд байна. Хамгийн гол нь бидний зайлшгүй мэдэх ёстой нэг зүйл бол Д.Сүхбаатарын аав Т.Дамдин одоогийн Сүхбаатар аймгийн Сүхбаатар сумын уугуул иргэн гэдэг нь гарцаагүй үнэн. Дээх нь үед "Морин толгойт" н.Дэндэв гэдэг хүн Жанжны эцэгтэй нэг нутагт өсч торнисон талаар дурсан ярьсан нь хожмоо түүхийн баримт болж үлдсэн. Тиймээс Т.Дамдин энэ яах аргагүй халх хүн. Ээж Ханд нь ч мөн халх хүн байсан талаар олон судлаачийн бүтээлд бий.

Энэ түүхэн хүний талаар хүмүүсийн мэддэггүй сонирхолтой баримтууд байдаг уу?

-Сонирхолтой баримт ховор байдаг. Учир нь ид залуу халуун насандаа өөд болсон болохоор энэ хүний талаарх баримт цөөн байх нь ойлгомжтой. Д.Сүхбаатар биеийн тамир, спорт, хөнгөн атлетик, ялангуяа цэргийн эрдэм, байлдааны ур чадвараараа бусдад гайхагддаг нэгэн байсан. Морин дээрээс гар буугаар бай оных, даавуунд боож газар тавьсан мөнгөн янчааныг шүүрэх зэрэгт тун чадварлаг байсны сацуу савлуур дээр дасгал хийхдээ маш шаламгай байсан талаар гэргий С.Янжмаа, партизан н.Гончиг зэрэг хүн ярьсан байдаг. Дээрээс нь Ардын хувьсгалын анхны ялалтыг тэмдэглэхээр 1921 оны 7 дугаар сарын 11-нд Да хүрээнд наадам хийх тухай Их жанжин Д.Сүхбаатарын 4 тоот тушаал гарсантай холбогдуулан дэлхий нийтийн биеийн тамир, спортын төрлөөс оруулан хөгжүүлэх нь зүйтэй хэмээн үзсэн. Нэгэн сонирхолтой баримтыг дурдвал "Нэг өдөр орос, монгол цэргийн дарга нарын дунд модон морин дээгүүр харайх тэмцээн зохион байгуулав. Модон морин дээгүүр орос цэргийн шовгордуу папах малгай дөрвийг тавиад харайх болоход ганц Д.Сүхбаатар ажиггүй давахад орос цэргүүд толгой сэгсрэх байсан" хэмээн бичигдсэн байх жишээтэй.

Хотынхоо төв талбайд хүрэл хөшөө болон заларсан энэ хүн зүгээр ч нэг баатар хүн байгаагүй юм шүү гэдгийг ойлгуулахын тулд залуу хойч үедээ юу гэж захиж вэ?

-Одоогийн зарим залуус түүхэн сэдэвтэй зүйлсийг ихээр цуглуулдаг болжээ. Цуглуулгатай байж болно. Тэгэхдээ тэрхүү цуглуулгаа бусдад таниулж, түүхийг нь сөхөж, дэлгэрүүлэх нь чухал. Хойч ирээдүй болсон залуустаа Д.Сүхбаатар шиг эх оронч, ард түмнээ гэдсэн сэтгэлтэй байх хэрэгтэй гэж л захимаар байна. Ямар нэг ажлыг тууштай хийж, хичээнгүй бай, хэзээ ч битгий шантраарай.

Бидэнтэй ярилцсанд баярлалаа. Таньд эрүүл энхийг хүсье!

Дэд ахлагч Т.ИДЭР


МЭНДЭЛСНИЙ 128 ЖИЛИЙН ОЙД

Н.Эрдэнэбаяр: “Д.СҮХБААТАР” КОМИКС НЬ АЛБ НЭГ НАМЫГ СУРТАЛЧИЛСАН АЖИЛ БИШ

“Нүүдлийн зурган өгүүлэмж” сангийн тэргүүн, хүүхдийн номын зураач, зохиогч Н.Эрдэнэбаяртай ярилцлаа. Уран бүтээлч маань өөрийн бүтээлээрээ дамжуулан үндэснийхээ үүх түүх, соёл, ёс заншил, өв уламжлалыг сурталчлан таниулдаг. Одоо тэрээр “Д.Сүхбаатар” комиксыг олны хүртээл болгохоор зорьж ажиллаж байна.

Их жанжин Д.Сүхбаатарын мэндэлсний 127 жилийн ойгоор “Сүхбаатар” намтарчилсан комикс номын нээлт болж байсныг тодхон санаж байна. Комикс хийх санаа анх хэзээ төрсөн бэ?

-Би хүүхэд байхын түүх сонирхдог, түүнийгээ хүүхэддэйн кино, комикс болгохыг мөрөөддөг байсан. Хамгийн анх 2004 онд “300 тайчууд”, 2006 онд “Бат хаан” комиксоо олны хүртээл болгож байлаа. Гэхдээ түүхэн сэдвээр комикс бүтээн гэдэг маш хүнд байсан. Судалгааны явц нэлээд ярвигтай.



Миний хувьд бараг 20-иод жил комикс зурж байна. Орчин цагт дэлхийн улс орнууд өөрсдийн түүхээ зурагт номд үлдээж байна. Бидний хувьд ч гэсэн энэ зорилгыг өвөртөлж төслөө эхлүүлчхээд явж байна. Төсөл маань 3 жилийн өмнөөс хэрэгжсэн. Бид эртний гэхээсээ 100 жилийн өмнөх түүхээ ч сайн мэддэггүй юм байна. Ардын хувьсгалын 100 жилийн ой дөхсөн үед жанжныа талаар бүдүүн бараг ойлголттой байж болохгүй гэж бодсон. Өнгөрсөн 3 жилийн хугацаанд жанжин Д.Сүхбаатар болон тухайн үеийн нөлөө бүхий түүхэн хүмүүсийн талаар тууштай судалж байна.

Энэ явцдаа 60-аад ном, 250 гаруй судалгааны материал дээр ажиллалаа. Түүхч, сэтгүүлч Г.Бадамсамбуу, зохиолын багийн залуус гээд 10-аад хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Тэндээс тун сонин үр дүн харагдсан нь Д.Сүхбаатар жанжны түүхийг сүүлийн 70 жил гуйвуулаад, 30 жилд нь мартсан байна. Бид эхэндээ хоёр дэвтрээр төсөөлж энэхүү комиксыг бүтээе гэж бодож байлаа. Тухайн үед Монголын Үндэсний брэндийн зөвлөлтэй хамтарч бүтээгээд, УИХ-ын дарга Г.Занданшатар хэвлэлтэд нь дэмжлэг үзүүлсэн. Ингээд өнгөрсөн оны 2 дугаар сарын 2-нд “Сүхбаатар” номынхоо нээлтийг хийсэн. Комикс маань 10 цувралаар гарна. Бидний төлөвлөснөөр энэ ондоо буюу Ардын хувьсгалын 100 жилийн ойд зориулж “Сүхбаатар” комиксын үлдсэн 8 цувралыг гүйцээж, улмаар 10 цуврал хүүхэддэйн кино, төдий тооны сонсдог номын хамт гаргана. Ирэх сард багтаж номынхоо шинэ цуврал, хүүхэддэйн нэг киног гаргахаар бэлдэж байна. Залууст хамгийн сонирхолтой хэлбэрээр хүргэхийг зорьж байгаа маань энэ.

Судалгааны явцад ямар шинэлэг баримт гарч ирэв? Тэр бүхнийг номдоо тусгаж чадсан уу?

-Түүхийн хүрээлэнгийн захирал, доктор Н.Хишигт бидэнд зөвлөдөг. Ер нь олдсон баримтуудаа бүгдийг нь тусгаж байгаа. Олон сонирхолтой баримттай танилцсан. Тухайлбал, Д.Сүхбаатар жанжин 1922 онд болсон улсын анхдугаар наадамд 20 харваж түрүүлэн, Богд хаанаас дөрвөн удаа бэйс цол хүртэж байсан зэрэг олон сонирхолтой баримтыг олж үзсэн. “Анхны 7” гэж нэрлэгддэг хүмүүс Оросоос хувьсгал экспортлож ирсэн гээд ярьдаг. Тэдгээр хүмүүс Орост дөрвөн сар байсан. Тэр хугацаанд яг ямар үйл явдал өрнөсөн талаар “Сүхбаатар” комиксоос олж мэдэж болно. Өөрөөр хэлбэл, бид нийтээрээ юу ойлгох вэ гэхээр, тусгаар тогтнол, эрх чөлөө, хувьсгалын төлөө хэн хэрхэн зорьж зүтгэж байсан талаар тодорхой ойлголттой болно гэсэн үг.

Та өмнө “Бумбардай” номоо гаргаж байсан. “Бумбардай” бол таны санаанаас урган гарсан дүр, гэтэл Д.Сүхбаатар бол хэн бүхний мэдэх түүхэн жанжин, цэргийн удирдагч. Тиймээс дүрээ гаргаж ирэхэд харьцангуй хялбар байв уу?

-Ийм түүхэн намтарчилсан комикс өнөөдөртөө Монголд байхгүй. Энэ утгаараа бидний хувьд шинэ сорилт болж байна.

“Бид түүхээ сайн мэддэг гэж боддог, гэтэл амьдрал дээрх мэдлэг нимгэн юм билээ” гэж та ярьж байсан. Судалгаанууд дээр ажилласны дараа ямар бодол төрж байна вэ?

-Бараг л Д.Сүхбаатар судлаач болж байна. 1911, 1921, 1990 он гээд хувьсгалын үе, мөчлөгөөр нь ярьж болно. Монголчууд 800-аад жилийн өмнө сэргэн мандаж, нүүдэлчин угсааныхаа төрт ёсоор бол 2000 жил замнаснаас сүүлчин 100 жилийг онцлоход эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөөх цаг үе байж. 1911 оны үйл явдлыг оруулбал 110 жил гэж болно. Том зургаар нь харвал, Манжийн зах хязгаар нутаг болж тусгаар байдлаа алдсанаас хойш 1911 оны эрх чөлөөний хөдөлгөөнөөс эхлээд 1921 оны хувьсгалыг хийн, дараа нь ЗХУ-ыг дагаж улмаар 1990 онд Ардчилсан хувьсгалаар шинэ нийгэм рүү шилжсэн. Монгол үндэстэн, эх орончид бүхий л цаг үед тусгаар тогтнолын төлөө тэмцэж ирсэн. Одоо ч

тэмцэж байна.

Бүх хүний мэддэг баатрын дүрийг шинэлэг байдлаар гаргаж ирнэ гэхээр их сонирхолтой санагдаж байна ...

-Д.Сүхбаатар жанжныг мэдэхгүй хүн үгүй. Гэхдээ энэ хүний талаар юу гэж боддог вэ гэхээр тоймтой зүйл хэлэх хүн цөөн. Тоймтой ойлголтгүй хүн бол цэргийн жанжин байсан л гэнэ. Түүхээ сайн мэддэг байх нь эх оронч үзэл, тусгаар тогтнолын ач холбогдлын талаар иргэд, хүүхэд залууст үнэн зөв мэдээлэл хүргэх ач тустай. Үнэ цэн нь ч өснө. Хамгийн их сурталчлагдсан мөртлөө хамгийн бага мэдэгдэж байгаа хүний ажил, амьдралыг сүүлийн үеийн баримтаар баяжуулж, илүүтэй таниулахгүй юм бол өөр хэнийг гэх вэ. Нөгөөтэйгүүр Ардын хувьсгалын 100 жилийн ой тохиож байна. Ийм давхцалыг ашиглаад, өнгөн дээрээ жанжин Д.Сүхбаатарын дүрээр комикс ном бүтээж байгаа боловч бидний цаад зорилго бол түүхээр контент бүтээх, түүнийгээ сонирхолтой хэлбэрээр хийж болдгийг харуулахыг зорьж ажилласан.

Хоёр цувралын ард гарчихлаа. Уншигчид хоёр цувралыг чинь хэрхэн хүлээж авав?

-Худалдаанд оруулах гэж төдийлөн оролдсонгүй. Уншсан хүмүүсийн хувьд ам сайтай байгаа.

Хүлээж авах хөрс нь бэлэн байсан юм байна гэж ойлгосон.

Борлуулах гэж нэг их оролдсонгүй гэхээр бүтээлдээ арилжааны бус хандсан ч юм шиг. Зах зээлийн нийгэмд таны барьж буй зарчим зөрчилдөж байгаа юм биш үү?

-Тэгж хандсан гэхэд өрөөсгөл. Удаашраад байгаа шалтгаан нь Ардын хувьсгалын ойд зориулж төслөө цогцоор нь хэрэгжүүлэх гэсэнтэй холбоотой. Нэг ёсондоо судалгаа, хөгжүүлэлт, хөрөнгө санхүү босгоход ихэнх цагаа зарцуулаад, борлуулалт сурталчилгаан дээрээ ажиллаж амжихгүй байна. Контентуудынхаа ард амжилттай гарчихвал цувралууд маань багагүй хугацаанд уншигдаж, яригдсаар байх болно гэсэн гэгээлэг хүлээлт байна.

Зарим ном кино болсны дараа номыг нь авах гэж шуурсан тохиолдол цөөнгүй байдаг. Таныг үүнтэй төстэй маркетинг хийж байна уу гэж бодлоо ...

-Нэгэнт ийм их хугацаа, хөдөлмөр, хөрөнгө мөнгө зарцуулж байгаа бол хүртээмжтэй хэлбэрээр нийтэд хүргэх нь чухал. Видео нь мэдээж контентын түгээмэл хэлбэр байх болно. Энэ утгаараа үзэгчид хүүхэддэйн киноноос агуулгыг нь илүүтэй ойлгох байх.

Түүхийн ямарваа нэг сэдвээр эрдэмтэд нэг талдаа гарч чадахгүй талцах нь бий. Тийм зүйлтэй тулгарч байв уу?

-Түүхчид судалгаа, баримт сайтай буюу илүү батлагдсан зүйл дээр дуугарах гэдэг. Уран бүтээлчдэд нэг давуу тал бий. Түүхэн баримтад тулгуурлаж хийж байгаа ч тодорхой хэмжээний уран сайхны арга хэлбэрийг ашиглах нь мэдээж. Бид 100 хувь түүхийн ном бичээгүй, үнэн бодит өгөгдөлд тулгуурлаад өөрсдийн шинэ санааг гаргаж, уран сэтгэмжээ ажиллуулж байгаа хэрэг.

Та цаашид Монголын төрийг удирдаж байсан удирдагчдаар комикс хийе гэсэн бодол бий юу?

-Дараагийн баатар хэн байх вэ гэдэг дээр ярьж байна. Дараагийн дүрээ тодорхойлоогүй байна. Гэхдээ маш олон санаа байна.

Ер нь соён гэгээрүүлэх ажилд төрийн оролцоо хэр үгүйлэгдэж байна вэ?

-Энэ контентоо олон нийтэд хүргэхийн тулд хувь хүн, яам, Засгийн газраар дэмжүүлэх сонирхол өндөртэй ажиллаж байна. Олон ч хүнтэй уулзсан. Хөрөнгө санхүү босгох тал дээр ажиллаад, болох талаас нь ярьж байгаа. Гэхдээ сүүлийн гурван жилд голлон өөрсдийн зардлаар энэ ажлыг хийж байна. Нөгөө талаас энэ онд 100 жилийн ой нь тохиох МАН, УИХ, Засгийн газар энэ мэт санаачилгыг дэмжиж ажиллах нь хар ухаанаар бодсон ч маш хэрэгтэй зүйл. Бидний хувьд ямар нэгэн ойд зориулсан, нам сурталчилсан ажил гэж харахгүй байна. Монголын түүх бол Монголын л түүх.

Түүхээ сурталчлан таниулах, ач холбогдлыг нь ойлгуулах, үнэн зөвөөр нь хүргэх өргөн цар хүрээтэй ажил гэж хэлмээр байна. Үүнийг олон сувгаар сонирхолтой хэлбэрээр хүүхэд залууст хүргэнэ. Уран бүтээлчидтэйгээ, төр засаг, хувийн хэвшилтэйгээ хамтраад 2021 онд багтаж энэ ажлыг дуусгаж, контентоо уншигч үзэгчдэдээ хүргэх нь бидний эрхэм зорилго. Д.Сүхбаатар гэдэг хүн 30 наслахдаа амьдралынхаа дийлэнх цаг хугацааг тусгаар тогтнол, эрх чөлөөний төлөө өөрийгөө зориулж тэмцсэн. Энэ тэмцлээрээ өнөөдөр бидэнд Ардын хувьсгалын 100 жилийн ойг тэмдэглэх боломжийг олгосон гэж хэлж болно.

Тиймээс нэг талаараа түүхээ сурталчлах, нөгөөтэйгүүр энэ хүний гавьяаг мөнхжүүлэхийн төлөө гурван жил хөдөлмөрлөж, Ардын хувьсгалын 100 жилийн ойд зориулж 30 контент хийх нь бидний, чухамдаа иргэн хүний үүрэг хэмээн бодож, ихээхэн ач холбогдол өгч ажиллаж байна. Энэ чиглэлд хамтарч ажиллаж гэсэн хувь хүн, албан байгууллагад бидний үүд хаалга нээлттэй шүү гэж хэлье.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ



Д.Сүхбаатар гэргий Н.Янжмаагийн хамт. 1917 он



Д.Сүхбаатар 1910-аад он



Ардын зураач, УГЗ О.Цэвэгжав. “1920 оны 06 дугаар сарын 25-ны өдөр Хүрээ ба Консулын хувьсгалт нууц бүлэглэлийн хурал болж нэгдэв”



Зүүн гар талаас: Д.Лувсандагва (“Жанжин” клубын дарга асан), МУГЖ Ч.Дашнамжил (Д.Сүхбаатарын дүрд тоглосон жүжигчин), Их жанжны хүү С.Галсан нарын хамт



Ардын зураач, УГЗ О.Цэвэгжав. “Хоёр нууц бүлгэм хуралдав”



БАТЛАН ХАМГААЛАХ ЯАМ-110 ЖИЛ

ЦЭРГИЙН ЯАМНААС ЯВАХ ЦЭРГИЙН ДҮРЭМ, ХЭМЖЭЭ ТОГТООЖ ДАГАЖ ЯВАХ ЯВДЛЫГ АЙЛТГААД БУУЛГАСАН ЗАРЛИГИЙГ СИЙРҮҮЛЖ МЭДЭГДЭН ИРСЭН ХЭРЭГ

(Үргэлжлэл нь №04-д)

Туг хиур хэрэглэхүй нь:

Нэгэн зүйл. Тугууд болбоос цөм оройд галаар ороосон илд, доорд улаан өнгийн хялгасан залаа дундад соёмбо үсэг, хоёр хажууд Монгол Улсын дэлхий дахины сүрийг бадруулагч зүүн баруун өмнөд хойд дунд хорооны дарга, ангийн түшмэлийн туг хэмээн тус тус ялган салгаж бичигтүн. Өөр өөрийн өнгөнд гал бадруулан хөвөөлж үйлдүүл.

Нэгэн зүйл. Аравны даргын хиурыг цөм тугийн өнгөөр үйлдүүл. Хороо тутам бүрт таван хиурыг тэргүүн, хоёрдугаар, гутгаар, дөтгээр, тавдугаар аравны даргын хиур хэмээн бичүүл. Хөвөө ба соёмбо үсгийг хэрэглүүлэхгүй болгогтун.

Бүрээ урамдал олгохуй нь:

Нэгэн зүйл. Ангийн түшмэл бүр бүрээ хошууд, урамдал нэжгээд, хороо тутам хэнгэрэг, харанга нэжгээдийг тус тус олгуулагтун.

Нэгэн зүйл. Хороо тутам жагсаалын түшмэл нэгийг талбиз хэнгэрэг харанга цохих ба бүрээ үлээх зэрэг жагсаалын аливаа бичгийн хэрэг зүйлийг эрхлэн шийтгүүл, цэргүүдийг сурган боловсруулж, алгуур түргэн хэрэгт осолдон цалгардахгүй болгогтун.

Бүрээ үлээхүй нь:

Нэгэн зүйл. Цэргийн газар орох гарах ба буудалласан газраас мордож гарахуйн урьд тэргүүн удаа бүрээ үлээхүйд эмээл тохож ачаа хөөхийг засцгаан бэлтгэж түшмэлийн газар хуралд, хоёрдугаар удаа бүрээ үлээхүйд дэс дараалан жагсаа, гуравдугаар бүрээ үлээхүйд нэгэн зэргээр мордогтун.

Цэргүүд урагш давших ба хойш эргэх нь:

Нэгэн зүйл. Байрлах газар, хэнгэрэг дэлдэхүйд урагш давшигтун. Харанга цохихүйд хойш эргэхтун.

Урамдалыг үлээхүй нь:

Нэгэн зүйл. Байлдах дайсны барааг үзсэн чачуу ангийн түшмэл даруй урамдалыг үлээж, олон цэргүүдийн зорчихыг зогсоож дуун чимээг гаргахгүй болгон зарлалыг хүлээгтүн.

Зэвсэг хэрэглүүлэхүй нь:

Нэгэн зүйл. Цэрэг тутам хурдан буу нэжгээдийг олгуул.


Цалин талбин олгуулахуй нь:

Нэгэн зүйл. Цалин хүлээн авахуйд сар бүрийн шинийн нэгэн, арван таван хоёр өдөрт хорооны дарга нарын газраас бүгд захирах даргад бичиг өргөн мэдүүлж, цалинг хүлээн аваад, цэргүүдэд тооны ёсоор талбин олгуулагтун.

Цэргүүдийг өдөр бүр хоёр удаа тунал байцаахуй нь:

Нэгэн зүйл. Харьат ангийн түшмэл, хорооны дарга нараас өглөө босмогц өөр өөрийн захирсан цэргүүдийг дэс дараалан тоолж байцаа, үдэш унтахын урьд мөн энэ ёсоор тоолон байцаагтун.

Хүнс худалдан авахуулахуй нь:



Нэгэн зүйл. Түшмэл цэргүүд элдэв газарт хүрч хүнс дуусч худалдан авахуй нь болбоос хороо ба ангийн дарга нараас бүгд захирах даргад өргөн мэдүүлж, мөн даргын газраас учрыг хянаж, бичиг тушаан өгсөн хойно худалдан авахуйд эр хонь хоёр лан, эм хонь нэг лан таван цэн, эр ямаа нэгэн лан, эм ямаа найман цэн, шар үхэр хорин лан, үнээ арван таван лангийн үнэ болгон хоёр этгээд харилцан найртай худалдаалсугай. Сүрдүүлэн дарлах ба боогдуулан гачигдуулж зоригоор нэмэх хасахгүй болгогтун.

Цэргүүдийг цээрлүүлэн шийтгэхүй нь:

Нэгэн зүйл. Цэргийн нууц хэргийг задруулан хэлэлцэх болбоос цаазар авчих хуульд холбогдох бөгөөд чухал цэргийн хүчинд эрэмшин хэрүүл цохион эдлэн, шударга ардыг жанчин зовоох эд агуурсыг албадан булаан авах, эхнэр охидыг халаан уулгаж үжид самгадыг үгүйсгэх ба түриймгийлэн дарлаваас цөм хүндэд шийтгэсүгэй.

Нэгэн зүйл. Түшмэл даргын тушаасан зарлалыг зөрчих ба цуу үг хэлэлцэх олныг бяцлахуй нь болбоос цөм хүндэд шийтгэсүгэй.

Нэгэн зүйл. Хүний амин, илтэд булаах ба битүү холгохуй нь болбоос цөм монгол цаазын хуучин хууль ёсоор ял торгож шийтгэсүгэй.

Нэгэн зүйл. Цэрэг зэвсгийг гэгдүүлэх, худалдах, арилжих, хэрвээ сумыг гэсэн ба худалдсан нь тавийн тоонд хүрвээс наян ташуур жанчих ял торгож, сумны илүүг нь улам улмаар зэрэг нэмүүлэн торгосоор таван зуун тоонд хүрвээс алах ял торгож, гянданд хорьж хүлээ. Жич буу нэг болбоос зуун ташуур жанчиж цэргээс байлгаж, хөтөч болгосугай. Хоёрын тоонд хүрвээс алах ял торгож, гянданд хорьж хүлээ. Санаатайгаар гэсэн, худалдсан ба осолдсон зэргийг цөм ялган шийтгэ.

Нэгэн зүйл. Цэргийн хорооноос зоримогоор ангижирч олон зүйлийн бие наадах, онх дарах, архи уух, манаа шивааг эндүүрэх, гэнэтхэн үймэлдэн цохилдон хэрэлдэх үе шигийг самууруулах, боловсруулахүйд осол уйтгтай болох, өртөөг албадан зовоох, бэлтгэлийн эдийг эвдэх сүйтгэх, айлыг цочоон айлгах, туг хиурыг тэнхээгүй болгох зэрэгт цөм хүнд хөнгөнийг ялган шийтгэсүгэй.

Нэгэн зүйл. Хөнгөтгөн шийтгэхүйд дөчин ташуур жанчсугай. Хүндэд шийтгэхүйд наян ташуур жанчсугай. Маш хүнд шийтгэхүйг зуун ташуур жанчиж цэргээс байлгаж хөтөчид хэрэглэсүгэй. Хэмээсэн үүнд нэмэн улаан бийрээр цохсон, зарлиг эдгээр хүнд хөнгөн ташуур жанчих ялыг харьяат цэргийг тусгайлан захирсан, үнэхээр шударга түвшинээр маш чангалан таслан шийтгэсүгэй. Үүнээс дээш алах ялд хүрвээс харьяат ялтныг Цэргийн хэргийг бүгд захиран шийтгэгч яамнаа уламжлан мэдүүлж гүйцэтгэн шийтгүүлэгтүн, хэмээжээ.

Нэгэн зүйл. Бүгд захирагчид дэслэн захирах, туслан шийтгэгч түшмэл нэжгээдийг байгуулж, цэргийн хэргийг хянан шийтгэх, санхүүг эрхлэн хадгалах, жагсаал дохиог хянан үзэх, чимээ мэдээ авах, манах сэргийлэхүйг хянах бичиг дансны зэрэг олон зүйлийг цөм өдөр бүр үзэн цаг бүр чангалж осолдон тасалдахгүй болгосугай. Хэрвээ оролдсон тушаасан хэргээ осол сул болгон хэрэг дэгдүүлэхүйд хүргүүлвээс эрхэн захирагч нарыг хүндэд шийтгэсүгэй.

МУУТА,ТБА, ХА-3. Д-1. ХН-493. Б-42

“ЭХ ОРНЫ ТӨЛӨӨ” НЭВТРҮҮЛЭГ-40 ЖИЛ

С.Болд: Ж.ГУРРАГЧАА БААТРЫН ТАЛААР АНХНЫ НЭВТРҮҮЛГИЙГ БИД ХИЙЖ БАЙЛАА

Тэртээ 40 жилийн өмнөөс өнөөг хүртэл хугацаанд залуусыг эх оронч үзлээр хүмүүжүүлэх зорилго бүхий цэргийн сэдэвтэй нэвтрүүлгүүдийг бэлтгэж, үзэгч олны хүртээл болгож байсан “Эх орны төлөө” нэвтрүүлгийн анхны найруулагч, чөлөөнд байгаа хошууч С.Болдын ажил амьдралынх нь түүхээс уншигчидтайгаа хуваалцлаа.

“Эх орны төлөө” нэвтрүүлэг үзэгчдийн хүртээл болсноос хойш даруй олон жилийн түүхийг өртөөлжээ. Энэ нэвтрүүлгийг бэлтгэх болсон урьдач нөхцөл юу байв?

-1981 оны 1 дүгээр сард Монголын Ардын армийн Улс төрийн газраас Л.Намдаг дарга намайг дуудлаа. Өрөөнд нь ортол Л.Намдаг гуай “За нөхөр минь чамайг МАХН-ын Төв хорооны шийдвэрээр Монгол телевизэд цэргийн сэдэвтэй нэвтрүүлгийн найруулагчаар томилж байна” гэв. Тухайн үед би дэслэгч цолтой, Ардын армийн дуу, бүжгийн ансамбльд найруулагчаар ажиллаж байсан. Л.Намдаг гуайд Ансамблийн найруулагчийн ажилдаа дөнгөж дадаж байгаа учраас тэндээ үлдэх хүсэлтэй байгаагаа цухуйлгатал хариуд нь “Цэргийн хүн тушаалаар хөдөлнө. Намын төв хорооноос Зэвсэгт хүчнийг сурталчлах тухай 468 дугаар тогтоол гарсан. Очиж ажлаа хүлээлгэж өг” гэдэг юм.

Л.Намдаг даргын өрөөнөөс гарангуутаа Ардын армийн дуу, бүжгийн ансамблийн уран сайхны удирдагч, дэд хурандаа н.Бадарчид илтгэлээ. Дарга хэзээний мэдчихсэн, ажлын амжилт хүсээд явуулж байсан. Надтай хамт БХЯ-ны Боловсон хүчний хэлтсийн мэргэжилтэн, дэслэгч Ц.Болд гэдэг залуу сурвалжлагч, редактораар томилогдож, бид хоёр Монгол телевизийн Залуучууд, спортын редакцын хамт олон дунд орж ажиллахаар болов. Ингэж л “Эх орны төлөө” нэвтрүүлгийн анхны найруулагч болсон түүхтэй.

Төрийн шагналт, Ардын уран зохиолч Ш.Сүрэнжав, сэтгүүлч н.Банзрагч нар Халхын голын байлдааны ялалтын 40 жилийн ойгоор буюу 1979 онд тусгайлан томилогдож нэвтрүүлэг хийж байсан нь Монгол телевизийн хамгийн анхны цэргийн сэдэвтэй нэвтрүүлэгт тооцогддог. Тэр үйл явдлаас хоёр жилийн дараа бид хоёр албан ёсны томилолтоор заасан орон тоонд ажиллахаар болсон гэсэн үг. Чухам яагаад энэ нэвтрүүлгийг гаргах болсон бэ гэвэл, 1970-1980-аад онд дэлхий нийтэд хүйтэн дайны цаг үе байлаа. Үүний хажуугаар манай урд хөрш бидэнтэй илт дайсагнасан байдалтай байв. Дээрээс нь манай улс армия өргөтгөж Сүхбаатар, Өмнөговь аймагт мотобуудлагын хороодыг байгуулж, Зүүнбаянгийн дивиз, Ховдын хороог томсгож орчин үеийн зэвсэг, техникээр хангах зэрэг хэд хэдэн ажлыг хэрэгжүүлж, арми маш хүчирхэгжиж байсан үе. Тиймээс тэрхүү хөгжил дэвшил, цэргүүдийн ёс журам, сахилга, зохион байгуулалт бүхий амьдралаар дамжуулж ард түмэнд эх оронч үзлийг төлөвшүүлэх, ахмад үеийн дайчин, баатарлаг уламжлалыг таниулах зорилгоор “Эх орны төлөө” нэвтрүүлгийг дээд удирдлагаас бэлтгүүлэхээр үүрэгдсэн хэрэг.

Мөн цэргийн хүн нэгдүгээрт нууцыг сайн хадгална, хоёрдугаарт хариуцлага хүлээх чадвартай хэмээн үзэж биднийг ажиллуулахаар болсон гэж боддог. Тэр үед цэргийн анги руу энгийн сурвалжлагч оруулдаггүй байсан. Ангийн байрлал, захирагч нарыг тэр бүр харуулж, цэргийн амьдралыг хэзээ ч муу муухайгаар үзүүлж болохгүйг үүрэгддэг байлаа.

Цэргийн шинелиэр жигдэрсэн хоёр залуухан офицерыг Монгол телевизийн хамт олон хэрхэн хүлээж авсан бэ? Тайзны найруулагчаас телевизийн найруулагч болох анхандаа амаргүй байв уу?

-Монгол телевизийн Залуучууд, спортын редакц гэж ямар сайхан хамт олон байсан гэж бодож байна. Тухайн үед тус редакцын хариуцлагатай редактор нь Хичээнгүй сайд Б.Цэрэндорж хэмээх түүхэн хүний ач охин, хожим тус телевизийн захирал болсон Ю.Эрдэнэтуяа гэдэг мундаг эмэгтэй байлаа. Редакцын бүрэлдэхүүнд найруулагч н.Бадрах, н.Жандал, н.Янжмаа, сэтгүүлч н.Дорж, Ш.Гүрбазар зэрэг алдартан багтдаг байсан. Харин телевизийн захирлаар нэрт сэтгүүлч М.Чойжил, орлогчоор нь СГЗ, нэрт сэтгүүлч Д.Жаргал нар ажилладаг байсан. Бид хоёрын хувьд телевизийн тухай ямар ч ойлголт байхгүй, гэнэтхэн л томилогдож ажиллахаар болсондоо сүрхий тулгамдаж байсан. Тухайн үед манай нэвтрүүлэг 14 хоногт нэг удаа 20 минутын хугацаатай гардаг байсан.

Нэвтрүүлгийн анхны дугаарууд ямар сэдвийн хүрээнд хийгдэж байв?

-Анхны нэвтрүүлэг 1981 оны 2 дугаар сарын 23-нд цацагдсан. Тэр дугаарт Зөвлөлтийн Армийн Тэнгисийн цэргийн флотын өдөрт зориулж гэрэл зураг, баримтат кино зэргийг нийлүүлж бүрэн хэмжээний нэвтрүүлэг хийсэн. Тус оны 3 дугаар сард монгол хүн анх удаа сансарт ниссэн. Сурвалжилгыг нь дэслэгч Ц.Болд бид хоёроор хийлгэхээр намын Төв хорооноос үүрэг өгснийг телевизийн захирлуудад уламжилж, улмаар ахмад Ж.Гүррагчаагийн тухай “Эх орны хүү” хөрөг нэвтрүүлгийг 3 дугаар сарын 28-нд бэлтгэн гаргасан нь Монгол хүн сансарт ниссэн талаарх хамгийн анхны нэвтрүүлэгт тооцогддог. Нөгөөдөр нь Ж.Гүррагчаа нисэгч эх дэлхийдээ газардаж байсан түүхтэй. Сонирхуулахад энэ сурвалжилгыг хийхийн өмнөхөн буюу 3 дугаар сарын 10 хавьцаа манай редакад хоёр ширхэг хар уут дүүрэн хальс ирсэн. Нэг нь Ж.Гүррагчаагийн, нөгөөх нь М.Ганзоригийн бичлэг байсан. Тэгээд кино монтажийн аппаратад нөгөө хоёр бичлэгээ оруулж эвлүүлэхээр боллоо.

Үүдэнд энгийн хувцастай НАХЯ-ны төлөөлөгч байнга хяналт тавина. Ийм нууцын зэрэглэл өндөр нөхцөлд бид тэр нэвтрүүлгийг хийж байсан. Хоёр бичлэгт Ж.Гүррагчаа, М.Ганзориг нарын нутагтаа очиж, хүүхдүүдээ эрхлүүлж, эмчийн үзлэгт орж сансарт нисэхэд бэлтгэгдэж байгаа зэрэг дүрс байсан. Тэдгээрээс ажиллагдсан нэг зүйл нь ахмад цолтой Ж.Гүррагчааг маршал Ю.Цэдэнбал, академич Б.Ширэндэв гуай нар хүлээн авч уулзаж, МХЗЭ-ийн Төв хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Л.Түдэв гуай шинэ батлах гардуулж өгч байгаа талаар дүрс орсон байв. Тиймээс миний бодлоор Ж.Гүррагчаа бол анхнаасаа л сансарт нисэхээр сонгогдсон хүн байсан. Учир нь 1971 онд ЗХУ-ын Фрунзе хотын нисэхийн дамжаанд нисэх онгоцны радиоэлектрон төхөөрөмжийн механикч мэргэжлийг эзэмшсэнээс гадна 1973 онд Москва хотод Жуковскийн нэрэмжит Агаарын цэргийн академид суралцаж төгссөн зэрэг давуу талтай байсан. Түүнээс биш заавал малчны хүүг сансарт нисгэнэ гээд багш хүний хүүг гэнэтхэн алаг үзсэндээ биш юм. Энэ талаар хүмүүсийн дунд буруу ойлголтууд байна уу гэж хардаг.

Монгол хүн сансарт ниссэн түүхэн үйл явдлаас хоёр сарын дараа буюу тухайн оны 5 дугаар сард бид ЗХУ-ын сансрын баатруудын тухай цуврал сурвалжилга бэлтгэн гаргасан. 16 мм-ийн кино хальсаар нэвтрүүлэг хийнэ гэдэг найруулагч, сурвалжлагч, редактор, зураглаачаас гадна



кино оператор, дууны найруулагч, техникч, эвлүүлэгч зэрэг хүмүүсийн гар бие, хичээл зүтгэл нийлж бүтдэг ажил байсан.

Тэгвэл их хариуцлагыг дагаад өндөр шалгуур тавигддаг байсан байх?

-Тэгэлгүй яах вэ. Бидний нэвтрүүлгийг манай Залуучууд, спортын редакцын хамт олон, главлит, Монгол телевизийн уран сайхны зөвлөлөөс эхлээд Ардын Армийн Улс төрийн газар, Батлан хамгаалах яам, Намын төв хорооны Үзэл сурлын болон Захиргааны хэлтсээс нэг бүрчлэн ирж үздэг байсан гээд бод доо.

Томилолтоор хэр их явдаг байв?

-Манай сурвалжлагч баг зөвхөн армийн хэмжээнд бус, хилийн бүх отряд, заставаар бүтгэн тойрсон. Очоогүй аймаг, сум маш цөөхөн. Дээрээс нь дотоодын цэрэг, цагдаагийн алба хаагчдаа ч хүрч ажилладаг байлаа. Хэдий хоёулхнаа ч гэсэн амжихгүй нь гээд хойшлуулж байсан удаагүй. Халхын голын байлдааны ялалтын 45 жилийн ойгоор буюу 1984 онд манай сурвалжлагч баг 10 цуврал нэвтрүүлэг бэлтгэж байсан. Тэдгээр нэвтрүүлэгт нийт 500 орчим хүн оролцсон гэдгээрээ маш том хүрээг хамарсан юм. Тэр ч бүү хэл Зөвлөлтийн баатруудын өгсөн ярилцлага манай ЭСЯ-аар дамжин бидэнд хаяглагддаг байлаа.

Тухайн онд Халх голд дөрвөн удаа очихдоо хилийн заставаас гадна Монгол-Зөвлөлтийн дайчдын сэдвээр сурвалжилга, нэвтрүүлгийг бэлтгэж байсан. Тэр үед дайнд оролцсон баатрууд, цэргийн зүтгэлтнүүд, ахмад дайчдын ихэнх нь амьд сэрүүн байсан. Тэдгээр түүхэн хүмүүстэй уулзаж, яриа сурвалжилга бэлтгэж явснаараа өөрийгөө азтайд тооцдог. Жишээ дурдахад, “Алаг морьт” Л.Дандар баатар, Д.Нантайсүрэн баатар зэрэг домогт цэргийн удирдагч нараас Хамар даваан дээр, Л.Гэлэгбаатар дайсны давшилтыг пулеметчин есөн нөхрийн хамт 10-уулхнаа тогтоон барьж эрлэхэг тулалдаж байгаад амь үрэгдсэн яг тэр газар нь очиж ярилцлага авч чадсан. Энэ бол дахин хэзээ ч давтагдашгүй маш ховор хувь тохиол байсан. Халхын голын байлдааны ялалтын 45 жилийн ойн хүрээнд хийгдсэн тэдгээр нэвтрүүлэг тухайн оныхоо шилдэг уран бүтээлд тооцогдож байлаа. Би Монгол телевизэд 1985 оныг хүртэл ажиллахдаа 200 орчим бүтээл хийсэн. Миний дараа найруулагч Н.Батсуурь, сэтгүүлч С.Дашням, яруу найрагч С.Дамдиндорж гэсэн хүмүүс томилогдон, нэвтрүүлгээ үргэлжлүүлж байсан.

Телевизэд ажиллаж байх үеийн мартагдашгүй дурсамжаасаа хуваалцахгүй юу?

-Халхын голын байлдааны ялалтын 45 жилийн ойд зориулан бид “Ахмад дайчдын уулзалт” нэвтрүүлгийг хийхдээ Зөвлөлтийн төв телевизийн “Чин сэтгэлээсээ” нэвтрүүлгийн хэлбэрийг ашиглаж бэлтгэсэн нь үзэгчдээс өндөр үнэлэлт авч байв. Халхын голын байлдааны фронтын шугамд мөр зэрэгцэн тулалдаж, татах тамхи, дайстай сум, дашмагтай усаа хуваалцаж явсан Монгол-Зөвлөлтийн ахмад дайчдыг нэвтрүүлгээрээ уулзуулж байсан. Сургамжтай, гунигтай нэгэн дурсамжийг энд онцолмоор байна. 1981 оны 12 дугаар сарын эхээр ЗХУ-ын дөрвөн удаагийн баатар, БНМАУ-ын баатар, маршал Г.К.Жуковын мэндэлсний 90 жилийн ой тохиож, нэвтрүүлэг хийх үүрэг дэслэгч Ч.Болд бид хоёр оногдов. Монгол кино үзвэрийн газраас “Маршал Жуков” гэсэн гурван бүлэг баримтат кино авч ирж нэвтрүүлгээ бэлтгэлээ. Маршал Г.К.Жуковын сайн мэдэхээр нь Батлан хамгаалахын сайд асан, хурандаа генерал Ж.Лхагвасүрэн гуайг урьж оролцуулсан. Ж.Лхагвасүрэн жанжин дурсамжаасаа хуваалцлаа. Маршал Г.К.Жуковын гарын үсэгтэй “Бодрол дурдатгал” номыг нь үзүүлж, бахархан ярьж билээ. Гэтэл Намын төв хорооны үзэл суртлын хэлтсээс хүмүүс ирж үзээд нэвтрүүлгийг хассан. Ж.Лхагвасүрэн жанжин Маршал Г.К.Жуковын хэмжээнд өөрийгөө магтсан, гаргасан амжилтаа хэт дөвийлгөж ярьсан мэтээр буруутгаж, гаргахгүйгээр шийдсэн байлаа. Хэд хоногийн дараа гэхэд тэр нэвтрүүлэг фондноос устгагдсан байсан. Тэр шилдэг цэргийн удирдагч хүний яриаг авч үлдэж чадаагүй нь тун харамсалтай.

Энэ салбарт хоёргүй сэтгэлээр алба хаасан хүний хувьд хойчийн ирээдүй болсон залуу үедээ юу гэж захиж вэ?

-Манай нэвтрүүлгийн баг нэг удаа Л.Дандар баатартай цуг Халхын голд очиж ярилцлага хийхээр болов. Халхын голын зүүн эрэг орчимд автобусаа зогсоогоод түр буудаллахаар шийдлээ. Л.Дандар баатар Гөлөгт манхан зүг заагаад “Т.Экей бол жинхэнэ баатар байсан юм шүү” гэж санаа алдсанаа “Их бууны суманд оногдоод гар нь санжчихсан, цээжээрээ дүүрэн шархтай байхад гэдсээ дараад “Эх орныхоо төлөө” гээд урагш мөлхөж байсан хүн дээ. Хүүхдүүд минь намайг уйлж байгааг нэвтрүүлэгтээ битгий оруулаарай. Би баатар цол авахдаа нулимс унагаагүй юм шүү. Харин М.Экейгийнхээ төлөө энд нулимс унагаагаа” хэмээж билээ. Хойч үеийн залууст хандаж хэлэхэд Л.Экей баатар шиг эх оронч, Л.Дандар баатар шиг чин сэтгэлээсээ байгаарай хэмээн захъя. Хамгийн гол нь эх орон ямар үнэ цэнтэй вэ гэдгийг монголчууд бид үеийн үед мэддэг байх ёстой.

Дэд ахлагч Т.ИДЭР



(Түрүүч нь I нүүрт)

Хүмүүс хоорондоо уулзаж, нийгмийн харилцаанд орох нь багасав. Энэ нь улс орны нийгэм, эдийн засаг төдийгүй дэлхий нийтэд, дипломат харилцаанд ч хямрал нүүрлэж, бүс нутаг дахь үл ойлголцол нэмэгдэхэд хүргэжээ. Цар тахлын халдвараас сэргийлж, төрийн дээд хэмжээний айлчлалууд цуцлагдаж, дипломатчид нүүр нүүрээ харж, харилцан суух боломжгүй боллоо. Гэхдээ эл асуудлыг цахим дипломат ажиллагаагаар шийдэж эхэлсэн байна.

Цахим дипломат ажиллагааг ихэнх улс нэвтрүүлэн гадаад бодлогоо сурталчилж, цаг хугацаа, хөрөнгө мөнгөө хэмнэхийн зэрэгцээ олон улсын тавцанд нэр хүндээ өсгөх болов. Ингэснээр мэдээллийн технологи, тэр дундаа интернэт нь дэлхий дээрх хамгийн хүчтэй, өргөн цар хүрээтэй, хүртээмжтэй холбооны хэрэгсэл болохоо нотлов. Өөрөөр хэлбэл, мэдээллийн технологи нь өөрөө дипломатын үүрэг гүйцэтгэж буйг илэрхийлж байна. Тухайлбал, АНУ-ын Ерөнхийлөгч асан Д.Трамп твиттер хуудсаараа дамжуулан бүхэл бүтэн улс орны ашиг сонирхол, бодлого, үйл ажиллагааг цөөн үгэнд багтаан бичихэд дэлхийн том хөрөнгийн биржүүд дээрх хувьцааны ханш хэдэн тэрбум ам.доллараар савлаж, түүнээс нь гэнэтийн их ашиг олдог мэргэжлийн хүн ч олширсон аж.

Бараг хүн бүхэн онлайн ертөнцөд амьдрах болсон



ЦАХИМ ДИПЛОМАТ АЖИЛЛАГААНД УЛС ОРНУУДЫН ЗЭВСЭГТ ХҮЧИН НЭГДЭЖ ЭХЭЛЛЭЭ

энэ үед дижитал дипломат ажиллагааны үр нөлөө үнэхээр хэмжээлшгүй болжээ. Мэдээллийн асар хурдацтай тархалт нь улс орнуудын харилцаанд эерэг болон сөрөг нөлөөг авчирч байна. Хэдийгээр аюулгүй байдал талаасаа сул ч дижитал дипломатын арга замыг нэвтрүүлж, ашиглахад дэлхийн зарим орон аль хэдийнээ анхаарлаа хандуулжээ. АНУ, Их Британи, Энэтхэг зэрэг улс одоогоор уг салбартаа тэргүүлэх чиг хандлагатай байна.

Энэтхэгийн Ерөнхий сайд Н.Моди нийгмийн сүлжээг идэвхтэй хэрэглэгчийн нэг бөгөөд жиргээнд найман сая дагагчтай. Түүгээр ч зогсохгүй Хятадад хийсэн айлчлалынхаа үеэр тус улсын дотоодын нийгмийн сүлжээ вейбод шинээр хаяг нээж, БНХАУ-ын Төрийн зөвлөлийн дарга Ли Көцянтай хамт авахуулсан зургаа оруулсан нь хүмүүсийн анхаарлыг татсан. Н.Моди, Ли Көцян хоёрын зурганд тэр өдөртөө 5000-аас илүү сэтгэгдэл бичигдэж, нүүр номоор 9300 удаа хуваалцаж, 600 мянган хүн лайк даржээ. Н.Модигийн вейбод нээсэн хаягийг 1.3 сая хүн дагажээ. Н.Моди ийнхүү Хятадын дотоодын нийгмийн сүлжээнд хаягаа нээснийг "Дижитал дипломат бодлого" хэмээн нэрлэв.

Ийнхүү үзэгдэл төдий байсан дижитал дипломат үйл ажиллагаа цар тахлын үед улам эрчээ авч, шинэ чиг хандлагыг авчирлаа. Үүнээс өмнө дипломатууд жиргээ, нүүр ном зэрэг сошиал хэрэгслүүдийг голчлон ашигладаг байсан бол коронавирус дэгдсэнээр энэ бүхэн эрс өөрчлөгдөж, төрийн дээд хэмжээний чуулгануудаас эхлээд сургуулиудын эцэг эхийн хурал, найз нөхдийн уулзалтыг видео хэлбэрээр зохион байгуулах шаардлага тулгарав. Үр дүнд нь "Zoom", "ezTALKS", "Skype" "WhatsApp" зэрэг арилжааны аппликэйшний хувьцаа хэд дахин нэмэгдэж, цахим орчны хэрэглээ өмнө байгаагүйгээр өслөө. Гэхдээ зарим улсын Засгийн газрууд өөрсдийн нууцлал өндөртэй цахим хурал хийх боломжтой аппликэйшнуудийг хөгжүүлж эхлээд байна.

Уламжлалт дипломат харилцаа үеэ өнгөрөөж, яриа хэлэлцээний талаарх бидний олон зуун жилийн ойлголт бүхлээрээ өөрчлөгдөхөд хүрлээ. Үүний

зэрэгцээ ирэх 10 жилд дэлхийн эдийн засгийн өсөлтийг Азийн улс орнууд жолоодох нь тодорхой болж, үүнд нь коронавирусийн дэгдэлт нөлөөлөхгүй гэж үзэж байна. Хөгжил сайтай орнуудын хүн амын хөгшрөлт, хөгжиж буй орнуудын залуучуудын их төрөлт зэрэг нь хүн ам зүйн бууралт, өсөлтөөс шалтгаалан интернэт хэрэглэгчдийн хувь хэмжээний дийлэнх хэсгийг Ази, Африкийн улсууд эзлэх болов.

Хүмүүс хөдөө аж ахуй эрхлэх нь багасаж, хотод суурьших болсноор угсаатан зүйн уусал эрчимтэй явагдаж, тэр хэрээр технологийг өргөнөөр ашиглаж байна. Ази тивийн хүн амын их өсөлтөөс шалтгаалж, дэлхийн түүхэнд урьд өмнө хэзээ ч байгаагүй олон сая иргэн дундаж ангийн давхарга руу түрэн орлоо.

Мэдээ мэдээлэл авах, нийгмийн харилцааны чиглэлээр цахим платформ хэрэглэх хүмүүс хэдэн саяараа нэмэгдсэний сацуу цар тахлын үед интернэт худалдаа өргөжиж, хил дамнансан тээвэр, харилцаа холбооны сүлжээнд татагдан орж, үйлчлүүлэх нь ердийн үзэгдэл болсны сацуу далайн тээврийн ачаалал нэмэгдэв. Хүлээн зөвшөөрөх, үгүй нь энд хамаагүй бөгөөд цар тахлын нөхцөл байдал биднийг цахим орчинтой илүү ойртуулж, хүн бүрийн амьдралын салшгүй нэг хэсэг болгон өөрчилж байна гэдгийг бид хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй болжээ.

Мөн хиймэл оюун ухаан ба автоматжуулалт нь ирээдүйн ажиллах хүчний шинэ хэлбэр болсноор хүн төрөлхтөн ямар нэгэн үйлчилгээ авахад цагийн ямар ч хязгааргүйн зэрэгцээ ажил, амралтын цаг гэсэн ойлголт үндсэндээ үгүй болж, харилцаа холбооны автоматжуулалтын хөгжил дэлхийн үйлчилгээний бизнесийн чиг хандлагыг тодорхойлох боллоо.

Нөгөөтэйгүүр дижитал дипломатын ажиллагаанд улс орнуудын Зэвсэгт хүчин нэгдэж эхэллээ. Сүүлийн жишээ гэхэд АНУ-ын Тагнуулын төв газар жиргээнд албан ёсны хаяг нээж, анхны жиргээгээ хийсэн нь тэр даруйдаа олон улсын анхаарлыг татав. Энэ мэт бусад улсын үндэсний аюулгүй байдлын байгууллагууд аль хэдийн өөрсдийн цахим хуудсаараа дамжуулан дэлхий дахинд албан ёсны байр сууриа илэрхийлдэг болжээ. Энэ нь ямар нэгэн зөрчилдөөнт цагийн байдлын үед жиргээ, нүүр ном зэрэг дижитал дипломат сувгийг ашиглан цаг алдалгүй өөрсдийн байр сууриа илэрхийлэх гэсэн хандлагатай холбоотой. Түүнчлэн хэн нэгэн сэтгүүлч эсвэл хэвлэлийн төлөөлөгчөөр дамжуулж зорилгоо илэрхийлэх нь эргээд өөрсдийн талд ашиггүй байдлыг үүсгэх, илэрхийлэх гэсэн гол санааг гуйвуулахгүй гэсэн аюулгүй байдлын байр суурьтай мөн уялдаж байна. Тухайлбал, Крымын хямралын үеэр Орос, АНУ хоёулаа Украинд болж буй үйл явдлыг өөрсдийн өнцгөөс цахим хуудсаараа дамжуулан тайлбарлаж байв. ОХУ-ын Гадаад хэргийн яам "Киев төрийн эргэлт гарч, Крым дэх Оросын цөөнхийн амь насанд аюул учраад байгаа учир бид яаралтай арга хэмжээ авах нь чухал" гэж жиргэсэн бол АНУ-ын тал "ОХУ Крымын хүн амыг хүчээр айлган сүрдүүлж санал асуулгад оролцуулсан нь олон улсын хэм хэмжээ, хүний эрхийг зөрчсөн явдал байлаа" гэсэн агуулгатай жиргээ оруулж байв. Энэ бол дижитал дипломатын арга ажиллагааг хоёр тал хэрхэн явуулж байсны тод жишээ.

Эдүгээ дэлхийн таван тивийн 70 гаруй улсын Зэвсэгт хүчин жиргээнд өөрийн хаягтай ба түүгээрээ дамжуулж үндэсний эрх ашгаа шууд илэрхийлдэг болсон. Тэр дундаа Израиль, Египет зэрэг улсын армийн албан ёсны твиттер хуудас нь маш идэвхтэй бөгөөд дижитал дипломат ажиллагааг өдөр тутамдаа маш үр дүнтэйгээр ашигладаг орнууд гэж үзэж болно.

Зэвсэгт хүчний байр суурийг ямар ч зөрчилдөөнт цагийн байдлын үед маш товч бөгөөд ойлгомжтойгоор богино хугацаанд өргөн хүрээнд илэрхийлэх арга нь дижитал дипломат ажиллагаа, тэр дундаа твиттер гэж үзэж болох юм. Энэ сувгийг ашиглаж хормын төдийд хэдэн мянган хүнд Зэвсэгт хүчний байр суурийг үнэн бодитоор ойлгуулах боломж ийн бүрдсэн аж.

Шинэ зэвсэг, техник



"КАЛАШНИКОВ" КОНЦЕРН ШИНЭ ЗАЛУУРТ ПУУЖИН ТАНИЛЦУУЛЛАА

ОХУ-ын "Калашников" концерноос "Стрела-10М" богино зайн агаарын довтолгооноос хамгаалах системд сууриглагдах шинэ "9М333" залуурт пуужинг танилцуулав.

Оренбург мужийн "Донгуз" туршилтын талбайд залуурт пуужингийн туршилтийн үйл явцууд амжилттай болсон байна. Тиймээс "Калашников" концерн ОХУ-ын Батлан хамгаалах яамтай байгуулсан гэрээнийхээ дагуу пуужингийн үйлдвэрлэлийг эхлүүлэхээр боллоо.

"Пуужингийн ялгагдах онцлог шинж чанар нь илүү нарийвчлалтай оптик контраст, хэт улаан туяаны болон долгион саатуулгаас хамгаалах гэсэн үндсэн гурван горимд ажилладаг. Ингэснээр бусад ижил төрлийн пуужингуудаас давуу талтай болсон" гэж "Калашников" концернийн хэвлэлийн алба мэдээлэв. "9М333" пуужин нь нам өндөрт нисэж яваа онгоц, нисдэг тэрэг, оптик саатуулгаар өөрийгөө бүрхсэн нисэх онгоц, дрон, далавчит пуужинд цохилт өгөх чадвартай аж.

Нүүрийг бэлтгэсэн ахмад М.МӨНХ-ЗОРИГ

А.Батбаатар: ЗӨВ ЦРТЭН БАЙХЫН НЭТ ШАЛТУУР НЬ ЦЭРТИЙН АЛБА ХААХ ЮМ

СУИС-ийн Дуурийн дуулаачийн ангид суралцаж байсан А.БАТБААТАР нэг л өдөр цэргийн алба хаахаар шийдэж, Зэвсэгт хүчний 340 дүгээр ангид татагдан иржээ. Түүнтэй цөөн хором ярилцлаа.



Уншигчдад өөрийгөө товч танилцуулахгүй юу?
-Би Завхан аймгийн Тэлмэн сумаас хугацаат цэргийн албанд татагдсан. Сургуулиасаа жилийн чөлөө аваад ирсэн.

Өөрийн биеэр үлгэрлэж цэргийн алба хаана гэхэд гэр бүлийнхэн тань юу гэсэн бэ? Таны шийдвэрийг танайхан хэрхэн хүлээж авав?

-Эр хүн байна даа, цэргийн алба хаасан нь зөв гэж бодсон. Нөгөөтэйгүүр цар тахлын үед ийм шийдвэр гаргасан нь их оносон гэж одоо боддог. Дараа нь сургуулиа төгсөж болно, нэг жил өнжлөө гээд оройтохгүй. Хугацаат цэргийн алба гэдэг амьдралын их сургууль гэсэн үг. Тиймээс энэ боломжийг ашиглаад залуу насандаа цэргийн алба хаая гэж бодсон. Аав ээж, гэр бүлийнхэндээ "Цэргийн албаа нэр төртэй хаагаарай" гэсэн та нарынхаа захиасыг сайн биелүүлж байгаа шүү гэж хэлье.

Цэргийн албанд татагдахаас өмнөх болон одоогийн А.Батбаатарын хооронд ямар нэг ялгаа гарсан уу?

-Анхандаа их хатуу, хэцүү газар байх гэж боддог байлаа. Эхэндээ өглөөний "Сэрээд, сэрээд" командад их түүртдэг байсан. Цэргийн анхан шатны бэлтгэл ч мөн амар байгаагүй. Гэхдээ албандаа маш хурдан дассан. Тэр хэрээрээ бодол минь ч асар хурдтай өөрчлөгдсөн. Цэрэгт бүх зүйл дүрмийн дагуу явагддаг. Тиймээс ямар ч асуудал тулгардаггүй гэж болно.

Миний хувьд цэрэгт ирэхээсээ өмнө бага зэрэг дотогшоогоо, бүрэгдүү маягийн хүн байсан. Ямартаа ч бага багаар нүүр хагарч байгаа. Бас хүнээс үг сондог, аливаа зүйлийг хийхдээ түүнийхээ үүрэг, хариуцлагыг хүлээнэ гэсэн сэтгэл зүйтэй болсон. Энэ нь аав хүнд байх ёстой хамгийн чухал чанар. Ийм чанарт сайн суралцаж байгаа. Манай ангид маш гоё жишиг бий. Чөлөөт цагаараа хугацаат цэргийн алба хаагчдынхаа гэр бүлд ая дууны мэндчилгээ дэвшүүлдэг. Өөрийн чаддаг зүйлээрээ бусдадаа тусалж байгаагаас гадна хоолойн дасгал, сургуулилтаа тасалдуулахгүй байгаа нь их олзуурхмаар. Хамгийн чухал нь би ирээдүйгээ маш томоор хардаг болсон. Сурч байгаа мэргэжлээ эзэмшсэн шиг эзэмшээд олныхоо хайр хүндэтгэлийг

хүлээсэн мундаг дуучин болно гэж төлөвлөсөн. Цэрэгт байх хугацаандаа тууштай чанарт нэрлэхлүүгээр суралцана гэж шийдсэн.

Бага багаар нүүр хагарч байгаа гэлээ. Цэргийн нөхөрлөл их нөлөөлсөн нь лавтай ...

-Би тийм ч олон найзтай биш. Цэрэгт ирээд онжавуудтайгаа сайхан нөхөрлөж байна. Монгол орны өнцөг булан бүрээс ирсэн олон аавын хөвгүүдтэй нэг зорилгын төлөө хамт алба хааж байгаадаа баяртай байна. Бидний нөхөрлөлийн үнэ цэн нь жаргал зовлонгоо хуваалцахаас гадна бие биеийнхээ сайн муу чанарыг хэлдэг, засах гэж оролддог оршдог. Тухайлбал, "Бади" буюу хамтрагчаасаа их зүйлийг сурч байна. Түүнийг Г.Одхүү гэдэг. Увс аймгаас хугацаат цэргийн албанд татагдсан. Үндэсний бөхийн спортод их хорхойсдог. Өөрөө ч бас барилддаг. Тангаргийн баярын барилдаанд нэгийн даваанд ойчихсон нь жаахан тиймхэн. /Инээв/

Төмөр замын бүтээн байгуулалтад оролцсон байлдагчдын талаар сонссон л байх. Танд ч бас тийм боломж нээлттэй. Тийм боломж олдвол яах вэ?

-Тэдгээр залуус жавхаатай, цог золбоотой харагдсангүй нуухгүй. Барилгын цэргийн ангид алба хааж байгаа болохоор төмөр замын бүтээн байгуулалтад оролцох боломж байгаа байх. Ерөнхийлөгч тус бүтээн байгуулалтад оролцож байгаа цэргийн алба хаагчдыг "Дотооддоо энхийг сахиулагч" хэмээн онцолж байсан. Сарын хугацаанд 2 сая гаруй төгрөгийн цалин авч байгаа нь энхийг сахиулагчидтай адилтгах нэг шалтгаан болсон байх. Хуримтлалтай болохын зэрэгцээ тодорхой ажил мэргэжилд дадаад халагдах нь байна шүү дээ. Надад ийм хүлээлт байгаа.

Зэвсэгт хүчний 100 жилийн ойг цэргийн албанд угтах нь. Догдлол байгаа л биз дээ ...

-Зэвсэгтхүчний 200 жилийн ойг үзэхэд бидний нас хүрэхгүй. Ардын хувьсгалын 100, Батлан хамгаалах яамны 110, Зэвсэгт хүчний 100 гэхчлэн төгш ойттой жил цэргийн алба хааж таарах нь. Мэдээж дээрх ойнуудыг ангидаа, онжавуудтайгаа утгана гэхээр догдолж байна. Хамгийн дурсамжтай, бахархалтай үе

минь байна гэдэгт эргэлзэх зүйлгүй.

Гэр бүлээ орхиод ирсэндээ санаа зовдог уу?

-Аав ээж маань Завхан аймгийн Тэлмэн сумандаа аж төрж байна. Эхнэрийг маань Л.Бадамгарав гэдэг. МУИС-ийг 2019 онд санхүүч мэргэжлээр төгссөн. Манай нутгийнх. Охин Б.Номин-Эрдэнэ маань нэг нас, гурван сартай. Хамгийн сүүлд тангаргийн баяраар гэрийнхэнтэйгээ ярьсан. Тэгэхэд эхнэр маань "Чамаараа бахархдаг шүү" гэж хэлсэн. Энэ үг надад их урам өгсөн.

Эхнэрийн чинь хэлсэн үг сэтгэлд тань их дотно бууж дээ. Та өөрөөрөө хэр бахархдаг вэ?

-Ер нь цэрэгт ирээд өөртөө их итгэлтэй болж, тэр хэрээрээ өөрөөрөө бахархах болсон. Иргэний цэргийн үүргээ нэр төртэй биелүүлж байгаагаараа бахархдаг гэсэн үг. Өглөө нэгдэж, төрийн далбаагаа мандуулах үеийн мэдрэмж хамгийн сайхан нь. Тэр үед хамгийн их омогшдог.

Ярилцлагаа сонгосон мэргэжлийн тань зүгт хандуулъя ...

-Багын л дуулах дуртай байсан. 2016 онд Завхан аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан "Үл тасрах аялгуу" уралдаанд тэргүүн байр эзэлж байсан. Мөн урлаг, соёлын бусад тэмцээнд дэд, тэргүүн байр эзэлж байв. Эмээ маань мэргэжлийн дуучин биш ч гэлээ их сайхан цээлхэн хоолойтой, ардын авьяастан хүн л дээ. Тэр авьяасаас нь өвлөж авсан юм уу даа гэж боддог. Аав ээж, төрөл төрөгсөд маань бас их эвлэгхэн дуулдаг хүмүүс. Би энэ авьяасыг мэргэжил болгохоор сонгосон учраас намайг гэрийнхэн маань тал бүрээр дэмждэг.

Дуурийн дуулаач мэргэжлийн онцлогийг юу вэ?

-Энэ бол сонгодог урлаг. Тэр утгаараа маш их авьяас, хөдөлмөр, зүтгэл шаарддаг. Хоолойны цар хүрээ ч мөн адил. Амьсгааны урлаг гэж хэлж болно.


Сүүлчийн асуултыг танд үлдээе ...

-Цэргийн алба хүнд тэсвэр тэвчээр, хатуужлыг олгодог. Маш олон зүйлд суралцах хэрэгтэй болдог. Залуу үеийнхэндээ хандаж хэлэхэд, зөв иргэн байхын нэг шалгуур нь цэргийн алба хаах юм шүү гэж хэлье.

Ярилцсанд баярлалаа.

Дэслэгч Ц.ЭНХ-ОРГИЛ

Үндэсний бахархал, өв соёл




ЭВЛЭЛИЙН ҮҮРҮҮД ИЙМ БОЛОХ ХЭРЭГТЭЙ

Очирын командалсан ангийн штабын дэргэдэх эвлэлийн үүр нь долоо хоногийн хагас сайн өдөр бүр ши буюу олон нийтийн дуу, тоглоом зэргийг эвлэлийн үүрийн нарийн бичгийн дарга Жамсрангаас тэргүүлэн цэрэг нийтийн дунд онц үлгэртэйгээр ажиллан буйг сайшаан тэмдэглэмой.

Батлан хамгаалахын Төв архивын сан хөмрөгөөс "Улаан одон" сонин. 1937.04.20 Дугаар №16 /422/ хуудас-2

ЭЛЭГНИЙ ӨВЧЛӨЛИЙН ҮЕД ЯМАР ХООЛ ХҮНС СОНГОХ ВЭ

Ихэнх шим тэжээлийн бодис элгээр дамжин хадгалагдах буюу бусад эд эрхтэн рүү хүргэгддэг. Эмийн солилцоо ч элгэнд я в а г д а х төдийгүй хоол хүнстэй хамт биед орж, биеэс хорыг гадагшлуулах, цөсийг ялгаруулж, өөх тосыг боловсруулахад тусалдаг. Элэг, цөсний өвчтэй хүнд өгөх хоолны химийн бүтцэд уургийг зохицуулах шаардлагатай байдаг. Хүнд хэлбэрийн өвчтэй үед амьтны гаралтай уургийг багасгана. Өөх, тосны хэмжээг нэлээд хязгаарлаж, нүүрс усны хэмжээг нэмэгдүүлнэ. Витамин С, Д, витамин В-12-ыг түлхүү хэрэглэнэ. тэжээлийн илчлэг нь 1800 ккал,



Ш и м

уураг 30 гр, нүүрс ус 320 гр агуулсан байх хэрэгтэй.

- Хэрхэн зөв бэлтгэх вэ: Ууранд чанаж болгох хэрэгтэй. Махаа машиндаж, давсыг багаар хийж, хэт халуун эсвэл хүйтнээр идэхгүй байх. Өдөрт 5-6 удаа хооллох хэрэгтэй.
- Элгэнд тустай хүнс: Сонгино, сармис, алим, загас, оливийн тос, бүхэл үрийн гурил, хушга, жүрж, хүрэн манжин, лууван, ногоон цай, авакода, нимбэг гэх мэт хүнсний түлхүү хэрэглэхийг хичээгээрэй.
- Хориглох хүнс: Шарж хуурсан өөх, тостой хоол, халуун ногоо, утсан болон нөөшилсэн бүтээгдэхүүн, хуршсан өрөм, шар тос, цуу жууцай, хийжүүлсэн ундаа ус, хиам, зайдас, адуу, гахайн мах, чинжүү, цагаан манжин зэргийг хэрэглэхийг хориглоно.

ЦТЭ-ийн ЯМЗТ-ын сувилагч, ахлагч. М.ЦОЛМОНТУЯА

ЭМГЭНЭЛ

ДАШЗЭВЭГИЙН ГАЛСАНТОГТОХ /1940-2021/



Бидний эрхэм сайхан алдартан, их хүндэтгэлийн эзэн Монгол Улсын Гавьяат жүжигчин, нэрт лимбэчин Дашзэвэгийн Галсантагтох тэнгэрийн орноо дэвшиж, Монголын урлагт нөхөж баршгүй гарз тохиолоо.

Ард түмэндээ "Тогдгор" хэмээн алдаршсан Д.Галсантагтох нь 1940 онд Өвөрхангай аймгийн Хайрхандулаан сумын нутагт мэндэлжээ. 1963 онд Сэлэнгэ аймгийн Соёлын ордонд дагалдан жүжигчин, 1965 онд Дархан хотын Соёлын ордонд жүжигчин, 1967 онд Ардын Армийн 017 дугаар ангийн хөгжмийн салаанд байлдагч, 1968-1982 онд МААДБА-д хөгжимчин, 1982-1985 онд Монголын зохиолчдын эвлэлийн хорооны "Ардын үлгэрийн танхим"-д хошин шогч, лимбэчин, жүжигчин, 1985-2000 онд Улсын циркэд алиалагч, жүжигчин, 2000 оноос чөлөөт уран бүтээлчээр ажиллаж байсан. 1968 онд байлдагч байхдаа Бүх ард түмний урлагийн наадмаас алтан медаль, 1971 онд Сэлэнгэ аймгийн Соёлын ордонд дагалдан жүжигчин байх үедээ Мэргэжлийн жүжигчдийн улсын уралдаанд оролцож тэргүүн байр, Дэлхийн залуучуудын оюутны IX их наадамд оролцон хүрэл медаль хүртсэн бөгөөд мөн ондоо МААДБА-д хөгжимчнөөр орж, алдарт лимбэчин, МУГЖ Майдарын Доржийн шавь болсноор мэргэжлийн жүжигчин, гоцлол хөгжимчин болтлоо өсөж, чадварлаг уран бүтээлчдийн эгнээнд хүрч чадсан билээ.

Тэрээр Монголын их урлагт 50 гаруй жил зүтгэхдээ төрийн болон түүхт ойн баярт зориулсан хүндэтгэлийн тоглолтууд, соёл урлагийн нэгдсэн арга хэмжээнд голлох үүрэгтэй оролцож, эх орныхоо бүх аймаг, сумд, Ардын армийн болон хилийн цэргийн нэгтгэл, анги, отряд, заставт хүрч, цэрэг дайчид, ард иргэдэд урлаг соёлоор үйлчлэн, гадаадын 50 гаруй улсад айлчлан тоглосон байна.

Соёл, урлагийг хөгжүүлэхэд нэгэн насны амьдрал, уран бүтээлээ зориулсан түүний хөдөлмөр зүтгэл, амжилтыг төр засгаас өндрөөр үнэлэн Хөдөлмөрийн гавьяаны Улаан тугийн одон, Монгол Улсын Гавьяат жүжигчин, "Соёлын тэргүүний ажилтан" цол тэмдэг, Байлдааны медаль, Ардын хувьсгалын 50, 60, 70, Зэвсэгт хүчний 50, 60 жилийн ойн медаль, "Онц хилчин" тэмдэг, цолоор тус тус шагнасан байна.

Таны минь бахдам авьяас, цэргийн соёл урлаг, Монголын хошин урлаг, циркийн урлагийн хөгжилд оруулсан үнэтэй хувь нэмэр, хамт олноо гэсэн энэрэнгүй сэтгэл, алиа хошин зан тань бидний зүрхэнд үүрд дурсагдах болно.

Гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсөд нь гүн эмгэнэл илэрхийлье.

ЦДБЭЧ-ЫН УДИРДЛАГА, ХАМТ ОЛОН, ГЭР БҮЛ, ТӨРӨЛ ТӨРӨГСӨД НЬ

СОЁМБО СОНИН
"Соёмбо" сонин 96 дахь жилдээ хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА, Д.НАЦАГДОРЖ

Дарга, ерөнхий редактор Хурандаа **САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ**
Эхийг "Соёмбо" сонини редакцияд бэлтгэж, "Соёмбо принтинг" хэвлэх үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламьг хямд нийтэлнэ.
*Зар, рекламьн үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл болон сонини нийтлэлийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонини мэдээллийг нэр заан ашиглаж болно.

Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс 10018
И-мэйл хаяг: Soyombo@mod.gov.mn
Утас: 70001029